

АХБ

ЖЕНДЭРИЙН ШАЛГУУР ЖАГСААЛТ

(Gender Checklist)



ХӨДӨӨ АЖ АХУЙ

АГУУЛГА

Жендэрийн шалгуур жагсаалтын зорилго	1
Хөдөө аж ахуйн төслүүдэд жендэрийн асуудал яагаад чухалд тооцогддог вэ?	1
Жендэрийн шалгуур жагсаалтыг хэрхэн ашиглах вэ ?	2
Төслийн үе шатанд тавигдах гол асуудлууд:	2
Төслийг Бэлтгэх Техник Туслалцааны /ТБТТ/ шатны мэдээлэл цуглуулах болон АХБ-ны ажилтнуудын анхаарах асуудлууд	3
ТБТТ-г хэрэгжүүлэхэд оролцох зөвлөхүүдийн анхаарах асуудал	4
Хөдөө аж ахуйн төслүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх, хамрах хүрээ	7
Үйл ажиллагаанууд:	8
Бараа үйлдвэрлэл болон үйлчилгээ	9
Нөхөн үйлдвэрлэл болон хүний нөөцийг чадваржуулах үйл ажиллагаа	10
Олон нийтийн ажил	10
Олон нийтийн байгууллага болон тэдгээрийн үйл ажиллагаа	10
Хүртээмж болон хяналт:	11
Хүртээмж болон удирдлагын хяналт	13
Бүтцийн болон нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн дүн шинжилгээ	15
Төслийн үе шатанд хийх дүн шинжилгээ, төлөвлөлтийн асуудлууд:	17
Үйлдвэрлэл	17
Сургалт	17
Мэдээлэл	18
Оролцоо	19
Хүртээмж	19
Тогтолцоог бэхжүүлэхүй	20
Төслийн хамрах хүрээ	20
Дэд салбарууд дахь жендэрийн дүн шинжилгээ:	22
Удиртгал	22
Усжуулалтын салбар дахь жендэрийн асуудлууд	22
Загас агнуурын салбар дахь жендэрийн асуудлууд	26
Байгальд түшиглэсэн эко жуулчлал дахь жендэрийн асуудлууд	30
Ой мод, усны аж ахуйн салбар дахь жендэрийн асуудлууд	31
Эрэг хавийн бүс нутгийн удирдлага жендэрийн асуудлууд	36
Хөдөө орон нутгийн цогц хөгжил дэх жендэрийн асуудлууд	38
Бичил санхүүжилт дэх жендэрийн асуудлууд	42
Аж үйлдвэрлэлийн зориулалттай газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх жендэрийн асуудлууд	45
Мал аж ахуй дахь жендэрийн асуудлууд	48
Хавсралт : Жендэрийн мэргэжилтэний ажил үүргийн хуваарь	51
Эх сурвалжуудын түүвэр	52

ТОВЧЛОЛ

ХА	Хэрэгжүүлэгч Агентлаг
ЖХ	Жендэр ба Хөгжил
АНҮ	Анхдагч Нийгмийн Үнэлгээ
ХҮ	Хяналт ба Үнэлгээ
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТБТТ	Төсөлд Бэлтгэх Техникийн Туслалцаа

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу. АХБ орчуулгын үнэн зөв эсэх талаар баталгаа өгөхгүй бөгөөд эх хувиас утга нь гажсан тохиолдолд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Хавтасны гэрэл зургийг Цагаан Будааны Эрдэм Шинжилгээний Олон Улсын Хүрээлэн хандивласан болно.

Гарын авлагын зорилго

Азийн Хөгжлийн Банкны Жендэр болон Хөгжил /ХХ/-ийн асуудлаархи бодлого, стратегийн зорилтууд /Азийн Хөгжлийн Банкны 1998 оны 5 дугаар сарын Жендэр болон Хөгжил /ХХ/-ийн асуудлаархи бодлогын баримт бичгийг үзнэүү/-ыг хэрэгжүүлэхэд тус банкны ажилтнууд болон зөвлөхүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулсан билээ. Төсөл, хөтөлбөрийн бүх үе шатанд хөдөө аж ахуйн салбар дахь жендэрийн асуудлуудыг тодорхойлох, жендэрийн асуудлуудаар жендэрийн мэдрэмжтэй стратегиуд, бүрэлдэхүүн хэсгүүд, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахад тусална.

АХБ-ны ажилтнууд төсөлд бэлтгэх техникийн тусалцаа /ТБТТ/-ны мэдээ баримт цуглуулах үед анхдагч нийгмийн үнэлгээ /АНҮ/-нд жендэрийн асуудлыг тодорхойлохдоо эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах нь зүйтэй. ТБТТ-ны явцад нийгмийн нарийвчилсан дүн шинжилгээг хийхдээ зөвлөхүүд үүнийг хэрэглэвэл зохино. Асуултууд бүгдээрээ бүх төсөлд хамаатай биш, тиймээс ажилтнууд болон зөвлөхүүд тухайн нөхцөл байдалд хамгийн зохистойг

сонгож хэрэглэх ёстойг цохон тэмдэглэх нь зүйтэй. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх төслүүдэд жендэрийн асуудлыг анхааран үзэж байгаа арга туршлагаас хуваалцах зорилгоор АНҮ-нд жендэрийн мэдрэмжтэй гарын авлага болон АХБ-ны төслүүдийн нөхцөл байдлын судалгаанаас зарим нэг жишээг энд тусган оруулсан болно.

Төсөл бэлтгэх явцад жендэрийн шалгуур жагсаалтыг «Төслүүдэд нийгмийн үзүүлэлтүүдийг тусгах АХБ-ны гарын авлага» /1994 он/, «Үр ашгийн мониторинг, үнэлгээний зааварчилгаа», Эмэгтэйчүүдийн асуудлаарх цуврал мэдээллүүдийн хамт хэрэглэх нь зүйтэй.

Эдгээр хяналтуудын жагсаалтыг орон тооны зөвлөх Пенелоп Шоэффэлын эхэлсэн ажлыг ашиглан Ширийн Латийф бэлтгэсэн болно. Монавар Султана дэд салбаруудын хяналтуудын жагсаалтад зарим нэгэн үнэтэй санал оруулж, хэд хэдэн кэйс судалгааг хийсэн бөгөөд эхийг Мэри Энн хянан тохиолдуулж, хэвлэлийн эхийг Жан Дэла Круз бэлтгэн, хэвлэлтэнд Элиса Ласерона тусалцаа үзүүлсэн болно.

Хөдөө аж ахуйн төслүүдэд жендэрийн асуудал яагаад чухал вэ?

Жендэрийн асуудлууд болон эмэгтэйчүүдийн оролцоонд анхаарах нь тухайн төслийн амжилттай, тогтвортой хэрэгжихэд нөлөөлдөг болохыг АХБ-ны санхүүжилт бүхий хөдөө аж ахуйн төслүүдээс харж болно.

Эмэгтэйчүүд фермерийн аж ахуйд хүч хөдөлмөрөө зарцуулах, уламжлалт ёс заншлаар гэрийн үнэлгээгүй хөдөлмөр эрхлэхээс гадна тэдний эдийн засгийн өсөлтөнд оруулах хувь нэмэр асар их байдаг. Гэсэн хэдий боловч олон оронд эд баялаг, үндсэн үйлчилгээг түгээх, шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийг ялган гадуурхах явдал оршсоор байгаа. Тэдгээр зааг ялгааг багасгахад АХБ-ны хөдөө аж ахуйн төслүүд их чухал ач холбогдолтой.

Төсөл нь хөдөө аж ахуй дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, эрэлт хэрэгцээ, ойлголт ухагдахууныг харгалзах ёстой бөгөөд жендэрийн тэгш бус байдлаас болж эмэгтэйчүүдэд тулгардаг хүндрэлүүд, ялангуяа төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, удирдахад тэдний оролцоог хязгаарладаг хүчин зүйлсүүдийг тооцож үзэх шаардлагатай. Тэдгээрийг эс харгалзвас төсөл удааширч саатах, хэрэгжилт нь зогсонги байдалд орох, тэрч байтугай төслийн ажиллагаа бүхэлдээ амжилтгүй болоход хүрдэг.

Жендэрийн тэгш байдалд ийнхүү анхаарахын ач холбогдол нь төслийн амжилттай ажиллагаагаар хязгаарлагдахгүйгээр үл барам төслийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилт, үнэлгээнд эмэгтэйчүүдийг идэвхтэй татан оролцуулах, шууд хамруулах, тэднийг чадваржуулах, өмчтэй болох гэсэн хүсэл эрмэлзэлийг төрүүлээд зогсохгүй, төслийг үр дүнг хүргэхэд илүү

ээрэгээр нөлөөлдөг. Хөрөнгө мөнгийг хүртээмжтэй болгосноор орлогоо нэмэгдүүлэх, өөрсдийн болон гэр бүлийнхээ эрэлт хэрэгцээг хангах, бусад үйл ажиллагаанд илүү цаг хугацааг зориулах боломжийг эмэгтэйчүүдэд олгоно. Энэхүү үр ашгийг улс орны эдийн засаг, цаашилбал нийт нийгмээрээ хүртэх болно.

Жендэрийн шалгуур жагсаалтыг хэрхэн хэрэглэх вэ?

Жендэрийн шалгуур жагсаалт нь жендэрийн тэгш байдлын дүн шинжилгээний хүрээнд үндэслэдэг бөгөөд иж бүрэн, уян хатан хэрэгжихэд чиглэдэг. Жендэрийн тэгш байдлын дүн шинжилгээ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрсдийн үйлдвэрлэж буй бараа, үйлчилгээ, тэдгээрийн хүртэмж хийгээд хөрөнгө мөнгийг захиран зарцуулахад ялгаатай оролцдог гэж үздэг ойлголтуудыг оруулдаг. Чухамдаа үйлдвэрлэлийн тогтолцоонд чиглэдэг хөгжлийн тусламжийн төслүүд дэх эмэгтэйчүүдийн оролцоог тодорхойлох үүднээс жендэрийн ялвартай тоо баримтыг цуглуулдаг.

Төслийн хэрэгжих явцад тавигдах гол асуудлууд

Төслийн үр ашиг хийгээд боловсруулалтыг сайтар нягтлан үзэхийн тулд жендэрийн дүн шинжилгээнээс үүдэн гардаг хоёр асуудлыг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал,

- Төсөлд хамрагдах нутагт түүний үр ашиг, үр дүнтэй төлөвлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, эрх мэдэл харилцан адилгүй байдгаас бодит амьдрал дээр ямар үр дагавар гарах вэ? Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцан адилгүй ялгаатай бадлыг төслийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх вэ?
- Тухайн төсөл эмэгтэйчүүдийн эрх мэдлийг дээшлүүлж, жендэрийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжихэд стратегийн ямар боломж бололцоог олгож байна вэ? Төсөл эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ? Жендэрийн тэгш байдлыг хангах урт хугацааны стратегид төсөл ямар хувь нэмэр оруулах вэ?

ТБТТны мэдээлэл цуглуулах АХБ-ны ажилтнуудад

Төсөлд бэлтгэх техникийн туслалцаа /ТБТТ/-ны явцад мэдээ баримт цуглуулахдаа анхдагч нийгмийн үнэлгээ /АНҮ/-г хийхдээ хяналтуудын жагсаалтыг ашиглахыг АХБ-ны ажилтнуудаас шаарддаг. АНҮ нь төслийн нийгмийн үр дагавар, түүний дотор жендэртэй холбоотой асуудлуудыг тодорхойлох, ингэснээр тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх, нөхцөл байдлуудыг тодорхойлоход АХБ-ны ажилтнуудад дөхөм үзүүлдэг. Энэ шатанд гүнзгийрүүлэн судлах жендэрийн гол асуудлуудыг нэгдүгээр хайрцагт тоймлон дурдсан болно.

Хайрцаг 1.

Анхдагч нийгмийн үнэлгээ /АНҮ/-нд тавигдах жендэрийн асуултууд

- Төслийн ашиг хүртэгсэд нь хэн бэ?
 - Ашиг хүртэгсдийг хүйсээр салгах, тоог гаргах
 - Эмэгтэйчүүд, түүнчлэн эрэгтэйчүүдтэй ярилцах
- Тухайн салбарт эмэгтэйчүүдийн оролцоо ямар байна вэ?
 - Хөдөлмөр эрхлэлтэн дэх жендэрийн хуваарийг ерөнхийд нь тодорхойлох
 - Тухайн салбарт эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээ эрэгтэйчүүдийнхтэй адил үү?
 - Боломжтой бол эрэгтэй, эмэгтэйчүүдийн орлогын гол эх үүсвэрийг тодорхойлно уу?
- Төсөл эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ? Төслийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адил эерэг болоод сөрөг нөлөө үзүүлэх үү?
- Төсөлд жендэрийн асуудлыг оруулж боловсруулах боломж бий юу? Эмэгтэйчүүдэд үр ашигтай, тэдний тэгш оролцоог хангах боломж бий юу?
- Төсөлд эмэгтэйчүүдийг хамран оролцуулахад тулгарах эрх зүйн зүй, соёл иргэншлийн болон сүсэг бишрэлийн хүндрэл бэрхшээлтэй асуудлыг тодорхойлно уу?
- Хэрэгжүүлэгч агентлаг нь төслийн үр ашгийг эмэгтэйчүүдэд хүргэх, тэднийг хамран оролцуулах чадвар бий эсэх?
- Жендэрийн мэдрэмжтэй төслийг төлөвлөхөд Төсөлд бэлтгэх техникийн туслалцаа /ТБТТ/-ны мэдээ баримт цуглуулах, ТБТТ-ны судалгааны ажилд ЖХ-ийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтний туслалцаа шаардагдах уу?

ТБТТ-г хэрэгжүүлэх зөвлөхүүдэд

Нийгмийн дүн шинжилгээ

Энэхүү жендэрийн жагсаалт нь төслүүдийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх зорилготой. ТБТТ-ны явцад жендэрийн дүн шинжилгээ хийх тойм, арга зүйн хүрээг бий болгодог. Жендэрийн дүн шинжилгээ нь үйлчлүүлэгчдийн доторхи эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үйл ажиллагаа, тэдний хөрөнгө мөнгөний хүртээмж, захиран зарцуулах боломж, нийгэм, эдийн засгийн үр дагаварууд, хүртээмж болон удирдлагын хэлбэрүүд, төслийн үр ашиг, төслийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийх бололцоог зөвлөхүүдэд олгодог байна.

Нийгмийн дүн шинжилгээн болон ТБТТ-ны төлөвлөлтөд харгалзан үздэг жендэрийн гол асуудлуудыг 2 дугаар хайрцагт дурдсан байна. Жендэрийн дүн шинжилгээ хийх аргуудыг дараагийн бүлэгт тайлбарлах бөгөөд хөдөө аж ахуйн төрөл бүрийн дэд салбарт харгалзан үздэг жендэрийн асуудлуудыг удаах бүлгүүдэд дурдах болно.

Нийгмийн үнэлгээний хүрээнд хийгддэг жендэрийн дүн шинжилгээ нь эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа болон хөрөнгө мөнгөний хүртээмж, захиран зарцуулах боломжийн талаархи мэдээллүүдийг цуглуулах, эмхэтгэх, эдийн засаг, нийгмийн бусад салбарыг судлах бололцоог олгодог. Жишээ нь хэн, юуг, хаана, хэдийд, ямар хугацаагаар, хэрхэн яаж хийв зэрэг олон мэдээллүүдийг цуглуулдаг. Мэдээллийг цуглуулах төдий нь хангалттай бус, гол нь төслийн төлөвлөлтөд тэрхүү мэдээллүүдийг ашиглахад гол ач холбогдол нь оршино. Жишээ нь шувуу үржүүлгийн аж ахуйг эмэгтэйчүүдийн эрхэлж байвал шувуу үржүүлэхэд чиглэсэн аливаа хөрөнгө оруулалтыг эмэгтэйчүүдэд хандуулж эмэгтэйчүүдийг төслийн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх талаар төслөө боловсруулах, төлөвлөхдөө анхаардаг. Тэрчлэн бүтээгдэхүүний борлуулалтыг эмэгтэйчүүд хариуцах тохиолдолд борлуулалтай холбоотой бүх мэдээллийг эмэгтэйчүүдэд чиглүүлэх учиртай. Төслийн төлөвлөлтөд анхаарагдах жендэрийн зарим гол хүчин зүйлийг 3 дугаар хайрцагт үзүүлсэн байна.

Хайрцаг 2

Нийгмийн үнэлгээ /НҮ/-ний жендэрийн гол асуудлууд

- **Зорилтот хүн амын бүлгийг сонгох, тодорхойлох.** Хүн ам зүйн мэдээллийг хүйс, насаар ялган ангилдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байр суурь, эдийн засаг, боловсрол, эрүүл мэндийн байдлын хувьд хэрхэн ялгаатай байдгийг анхаарч үзэх шаардлагатай.
- **Жендэрийн хөдөлмөрийн хуваарийн талаар мэдээлэл цуглуулах.** Хэн, юуг, хаана, хэдийд, ямар хугацаагаар хийх вэ? Үйлдвэрлэл, айл өрх, нийгмийн үүрэг хариуцлагаа хэрхэн хуваариладаг вэ?
- **Хүн амын тодорхой хэсгүүдийн хоорондын ялгааг нягтлах.** Уг бүлгүүд дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байр суурь, эрх мэдэл, аж байдлын ялгаатай байдлыг тодорхойлох
- **Төслийн хүн амын зорилтот бүлгүүдийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг үнэлэх** Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр тэргүүлэх зорилттой байдаг эсэх, тэдгээрийн ялгаа нь төлөвлөж буй төсөлд хэрхэн нөлөөлөхийг анхаарч үзэх.
- **Чадварыг үнэлэх** Төсөлд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хэрхэн оролцох, тэдний эрмэлзэл, мэдлэг, дадлага, болон зохион байгуулалтын боломж, төсөл тэдгээр хүмүүсийн соёл, нийгэмд хэрхэн зохицож байгаа зэргийг авч үзэх.
- **Нөөцийн хүртээмж, захиран зарцуулалтанд үнэлгээ хийх.** Эмэгтэйчүүдийн нөөцийг ашиглах, хүртэх, захиран зарцуулахад төслийн үйл ажиллагаа эсрэгээр нөлөөлөх үү? Жишээ нь тэдний газар, ой мод ашиглах, зах зээлд хүрэх боломж, бололцоо нь багасах уу?
- **Тогтолцооны чадавхийг үнэлэх.** ХА нь үйлчилгээг эмэгтэйчүүдэд хүргэх чадвартай юу? ХА нь эмэгтэй ажилтан, туслан гүйцэтгэгчтэй юу?
- **Байгууллагуудыг сонгох.** Эмэгтэйчүүдэд чиглэсэн, жендэрийн болон хөгжлийн асуудлыг сонирхдог төрийн болон төрийн бус ямар агентлаг, байгууллага төсөлд хувь нэмрээ оруулж болохыг анхаарч үзнэ.

Хайрцаг 3

Төслийн боловсруулалт, төлөвлөлтөд харгалзан үзэх жендэрийн гол асуудлууд

Оролцооны арга: Төслийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил тэгш байдлаар оролцуулж тэдэнтэй зөвлөнө.

Жендэрийн дүн шинжилгээ

- Төслийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алинийх нь эрэлт хэрэгцээг тодорхойлсон уу?
- Эмэгтэйчүүдийн оролцоонд саад учруулж байгаа нийгэм, шашны болоод соёлын хэм хэмжээг саад бэрхшээлийг тодорхойлсон уу?
- Тэдгээр бэрхшээлийг шийдвэрлэх, даван туулах арга барилаа томъёолсон уу?
- Орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагуудтай зөвлөлдсөн үү?
- Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдээс эмэгтэйчүүд ашиг хүртэж чадах уу?

Төслийн төлөвлөлт, боловсруулалт

- Нийгмийн хийгээд жендэрийн мэдээлэл, дүн шинжилгээг төслийн үечлэлийн бүх шатанд ашиглана
- Төслийн төлөвлөлт, боловсруулалт нь төсөлд эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог хөхүүлэн дэмжих, хэрэгжихүйц бүрдэл хэсэг, арга барил, стратеги, төлөвлөлтийн онцлог эсвэл зорилтыг агуулж чадаж байна уу
- Төлөвлөлт, боловсруулалтын эдгээр онцлог, стратеги, болон механизмуудад зориулан төслийн төсвөөс хөрөнгө хуваарилах эсэх ?
- Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд бие даасан тусгай төсөв бий болгох асуудлыг анхаарч үзэх
- Эмэгтэйчүүдийг оролцуулах стратеги, зорилтууд төслийн орон нутгийн хүрээнд тусгагдсан эсэх ?
- Төслийн хэрэгжүүлэхдээ жендэрийн арга туршлагыг хэрэглэх асуудлыг анхаарч үзэх
- Хэрэгжүүлэгч агентлагийн ажилтнуудын жендэрийг төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх талаар анхаарч үзэх

Үр ашгийн хяналт болон үнэлгээ


- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүртэж буй үр ашгийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд бий эсэх ?
- Эмэгтэй, эрэгтэйчүүдэд төслөөс хүртэх ашгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох
- Жендэрийн нөлөөг судалж тогтоохын тулд жендэрийн ялгавартай тоо баримтыг цуглуулж байгаа эсэх
- Хяналт болон үнэлгээнд эмэгтэйчүүдийг хамруулан оролцуулах асуудлыг анхаарч үзэх

Хөдөө аж ахуй дахь жендэрийн дүн шинжилгээг хийх хүрээ

Жендэрийн дүн шинжилгээ хийх хүрээ нь дөрвөн бүлэгтэй бөгөөд хоёр үндсэн шатаар дамжиж хэрэгждэг. Нэгдүгээрт: Үйл ажиллагааны шинж байдал, хүртээмж, хяналтын талаархи мэдээллийг цуглуулдаг. Үйл ажиллагаа, хүртээмж болон хяналтад нөлөөлөх хүчин зүйлүүд, хандлагууд, төслийн хэрэгжих бүхий л шатанд тэдгээр мэдээллийг ашиглана.

Зураг 1-ээс төслийн жендэрийн дүн шинжилгээний үе шатуудыг харж болно.

Зураг 1
Төслүүдийн жендэрийн дүн шинжилгээ



Үйл ажиллагааны шинж байдал

Тухайлсан үйл ажиллагааг явуулахын тулд төсөлд хамрагдах нутаг орны хүн амын тодорхой хэсгийн, түүний дотор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлагыг сайтар мэддэг байх шаардлагатай. Тийм учраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо, тэдний дангаараа болон бусадтай хамтран хэрэгжүүлэх зорилтууд, жендэрийн хөдөлмөрийн хуваарь хэр тогтвортой байдаг талаархи мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Гол зорилго нь төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийг ямар нэгэн байдлаар хохирохгүй байлгахад оршино.

Үйл ажиллагааны төлөв байдал нь үйлдвэрлэл, нөхөн үржихүй¹, олон нийтэд хандсан үйлчилгээ зэрэг бүх төрлийн үйл ажиллагааг авч үздэг. Ингэхдээ тухайн үйл ажиллагаа бүрд хэдий хэр хугацаа зарцуулагдсан, хэр тогтмол үйл ажиллагааг явуулдаг /өдөр тутам эсвэл улирал бүр гэх мэтээр/ аль үед эрэлт хэрэгцээ нь өсдөг, хөтөлбөрийн улмаас эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүдэд ямар нэгэн нэмэлт шаардлага тавигдах зэргийг мөн харгалзан үздэг.

ЗӨВЛӨМЖ

Төсөлд эмэгтэйчүүд
идэвхтэй ороцож
байгаад хяналт
тавьж төсөлд
оролцоноороо
эмэгтэйчүүдэд
ямар нэгэн хохирол
учрахгүй байх
зэрэгт анхаарлаа
хандуулах

Үйл ажиллагааны төлөв байдал нь тухайн үйл ажиллагаа хаана /тухайлбал гэр бүлд эсвэл тосгонд, зах, тарилангийн талбайд, хот суурингийн төвд гэх мэтээр/ явагддаг, тэдгээр нь гэрээс хэр зайтай байдаг зэргийг тус тус тодорхойлдог. Эдгээр мэдээллийн дүнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шилжих хөдөлгөөний талаар дэлгэрэнгүй ойлголт авахаас гадна уг төсөл шилших хөдөлгөөнд ямар нөлөө үзүүлэх, нүүдлийн уналга хэрэгсэл, үйл ажиллагааг ядуулахад аян замд зарцуулах болон хэмнэж болох цаг хугацааны талаар нарийвчилсан төсөөлөлийг олгодог.

Үйл ажиллагааны төлөв байдалд дурдагдсан дөрвөн төрлийн үйл ажиллагааг дор өгүүлэв. Үүнд:

¹ Эдийн засгийн бус нөхөн үйлдвэрлэл болон хүний нөөцийн үйл ажиллагаанаас ялгардаг үйлдвэрлэлийн буюу эдийн засгийн үйл ажиллагаанд айл өрх, олон нийтийн эдийн засгийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн газар тариалан, мал аж ахуй, гар үйлдвэрлэл, боруулалт болон хөлсний ажлууд багтдаг. Нөхөн үржихүйн болон хүний нөөцийг арвижуулах ажиллагаа нь нөхөн үйлдвэрлэл болон гэр бүл, олон нийтийг асран халамжлах, тухайлбал, түлш, ундны ус татах, хоол бэлтгэж хүнс төхөөрөх, хүүхэд багачуудыг асран халамжлах, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, гэр орноо авч явах зэрэг ажлууд багтдаг. Эдгээр ажил бүхэлдээ цалин урамшуулал шаарддаггүй, үндэсний хэмжээний ашиг орлогод ч тусгагддаггүй.

Бараа үйлдвэрлэл, үйлчилгээ

- Эмэгтэйчүүд амьжиргааны болон үр тарианы үйлдвэрлэлийн аль алинд идэвхтэй оролцдог уу?
- Фермерийн үйл ажиллагааны бүх шатанд зорилтот бүлгийн ажлын ачаалал ямар байдаг вэ? Ажлыг ямар улиралд хийж байна? Эдгээр асуултыг амьжиргааны болон газар тариалангийн үйлдвэрлэл дээр /үр суулгах, ургац хураах, газар боловсруулах, тариалах буюу үр суулгах, зэрлэг зулгаах, тариалах, хадгалах, нөөцлөх, боловсруулах буюу хоол хүнс болгож хувиргах, маркетинг/ эсвэл мал аж ахуй /шувууны, сүүний, загасны, зөгийн үйлдвэрлэлт болон боловсруулалтын/, модны аж ахуйн үйлдвэрлэл зэрэг асуудлуудаар тус тус тавина.
- Ажлыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүүхдүүд хамтарч эсвэл дангаараа гүйцэтгэдэг үү?
- Төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудад эрэгтэйчүүд эсвэл эмэгтэйчүүд нийгэм соёлын хэм хэмжээнээсээ болж тусгаарлагдан оролцохгүй байдаг уу?
- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ямар нэгэн хэмжээгээр /цар хүрээг нь тодорхойлох/ бэрхшээл, ажлын ачаалал, ашиг орлогын улмаас аль нэгэн ажлыг нэг нь нөгөөгөөсөө шилжүүлэн авдаг уу?
- Өрх гэр бүлийн бүтцэд гарсан өөрчлөлт жендэрийн хөдөлмөрийн хуваарьт ямар хэмжээгээр нөлөөлөх /шилжин явж ажил эрхлэх/ вэ? Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн байдлыг энэ талаар онцлон судалбал зохино.
- Эмэгтэйчүүд эсвэл эрэгтэйчүүдийн хөдөө аж ахуйн салбарт хийж байгаа үйл ажиллагаа нь тэдний ажлын цагийг нэмэгдүүлэх үү?
- Эмэгтэйчүүдийн хөдөө аж ахуйд гүйцэтгэдэг ажилд тус дөхөм үзүүлэх шинэ техник технологийг нэвтрүүлэх үү?

Ямар бодлого, хөтөлбөр нийгэм-соёлын хэм хэмжээнүүд эмэгтэйчүүдийг төсөлд оролцоход нөлөөлж байна вэ?

Нөхөн үйлдвэрлэл болон Хүний нөөцийн үйл ажиллагаанууд

- Өрхийн нөхөн үйлдвэрлэл болон ам бүлийн гишүүдийг асран халамжлах ажлыг хэн хийдэг вэ? Эдгээр ажилд үр хүүхэд, өндөр настнаа асран халамжлах, хоол хүнсээ бэлтгэх /өрхийн хүнсний хэрэгцээнд зориулсан газар тариалан, мал аж ахуй эрхлэх, дэлгүүр хошооноос бараа худалдан авах, хоол хүнс бэлтгэх, чанаж болгох гэх мэт/, түлээ түлш, ундны ус татах, боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, угаалга, цэвэрлэгээ, орон сууцаа барьж байгуулах, урлалын зориулалтаар болон гар үйлдвэрлэл, нийгмийн өмнө хүлэсэн үүргүүдээ гүйцэтгэн биелүүлэх гэх мэт ажил багтана.
- Ямар хугацаа шаардагдах вэ?

Олон нийтийн ажил

- Орон нутгийн түвшинд олон нийтийн ажил /ус хангамжийн байгууламж, хурал цуглааны болон мөргөлийн байр танхим зэрэг нийтийн газруудыг харж хамгаалах, ажиллуулах/-ыг хэн зохион байгуулж, хэрэгжүүлдэг вэ?
- Эдгээр ажлыг гүйцэтгэхэд хэр цаг хугацаа шаардагдах, хэдийд хийж дуусах вэ ?

Олон нийтийн байгууллага, үйл ажиллагаа

- Төслийг хэрэгжүүлэх нутаг оронд олон нийтийн ямар төрлийн байгууллага /нийгэм-соёлын уламжлалт байгууллагууд, хоршоод гэх мэт үйлдвэрлэгчдийн холбоод, хадгаламж зээлийн бүлгүүд, төрийн бус байгууллагуудаас зохион байгуулагддаг олон нийтэд түшиглэсэн байгууллагууд/ байдаг уу?
- Олон нийтийн эдгээр байгууллагуудын гишүүнчлэл, зорилго, стратеги, үйл ажиллагаа нь хэр цаг хугацаа шаарддаг вэ?

Хүртэмж болон удирдлагад тавих хяналт

Хүртэмж болон удирдлагад тавих хяналт нь хүртэмж болон удирдлагад тавих хяналт нь газар, тоног төхөөрөмж, ажил хөдөлмөр, хөрөнгө мөнгө, зээл, боловсрол, сургалт гэх мэт үйлдвэрлэлийн нөөц боломжуудыг харгалзан үзэх бөгөөд тэдгээр хөрөнгө мөнгөний хүртэмж, хуваарилалт, ашиглалтын холбоотой шийдвэр гаргах үйл явцад тавих хяналтад зааг ялгаатай ханддаг. Ингэснээр төслийн үйлдвэрлэлийн нөөц боломж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэрийг өөрчлөх, нөөцийн хянах эмэгтэйчүүдийн эрх мэдэл зэргийг авч үзэх боломжийг төлөвлөгчдөд олгодог байна.

Эмэгтэйчүүд газар, эд хөрөнгө, тоног төхөөрөмж, болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлийг эзэмших эсвэл хүртэх талаар хэрхэн оролцдог вэ?

Хөдөө аж ахуйн төслүүдэд эмэгтэйчүүдийг эрх тэгш оролцуулахад саад учруулдаг хүчин зүйлсийг шинж байдлаар нь нягтлан үздэг. Жишээ нь хэрэв эмэгтэйчүүдэд орлого, газрын хүртэмж тодорхой хэмжээний хязгаартай байдаг бол тэд үйлдвэрлэлд оролцох, арилжаа хийх боломж нь хязгаарлагдмал, бие даасан үйлдвэрлэл эрхлэх, хөдөө аж ахуйн нэгдэл хоршоололд оролцож чадахгүй. Дээрх байдал зарим талаар эрэгтэйчүүдийг ч давхар хохироодог.

Төсөл нь хөдөө аж ахуйд эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэг үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх шинэ техник технологийг нэвтрүүлэх үү?

Хөтөлбөрийн удирдлагын менежмент нь үйлдвэрлэлийн хэрэгсэл хэнд хүртэмжтэй, хэний хяналтад байгааг тодорхойлох төдийгүй, тухайн жендэрийн харилцааг ч өөрчилж болно /Хүртэмж болон удирдлагад тавих хяналтын шинж байдлын талаар 4 дүгээр хайрцагнаас харна уу/.

4 дүгээр хайрцаг

Хүртээмж болон удирдлагад тавих хяналтын шинж байдал

Үйл ажиллагаа

- Өрхийн аль гишүүн ХАА-н үйлдэрлэлд ямар үүрэгтэй оролцдог, жендэрийн ялгаанд суурилсан хөдөлмөрийн хуваарь хэр зэрэг хатуу мөрддөгддөг вэ?
- Хөдөлмөрийн зах зээл дэд ажил олдох нь хоногоор болон улирлаар хэрхэн өөрчлөгддөг вэ?
- Өрхөд аль гишүүн ямар ажил, үүргийг хариуцдаг вэ?

Нөөц болон хүндрэл бэрхшээлүүд

- Газар, хүний нөөц /боловсрол, мэдээлэл, мэдлэг, сургалтанд хамрагдах боломж, үйлдвэрлэлийн өргөтгөх үйлчилгээ гэх мэт/ эд хөрөнгө гэх мэтийн үйлдвэрлэлийн нөөцийг хэн хүртэж хянаж байна вэ?
- Үйлдэрлэлийн нөөцийн хүртэх, хянах боломжгүй байгаа хүмүүсийн хувьд ямар хүндрэл бэрхшээлүүд гардаг вэ?
- ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрх болон хүмүүсийн эрэгтэй эсвэл эмэгтэйн хэн нь ямар шийдвэр гаргадаг вэ?
- Тохиолдож буй бэршээл хүндрэлүүд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ямар ялгаатай байдаг вэ? Энэ ялгаа нь тэдний ажил, хөдөлмөрийн бүтээмж, үр ашгаас хүртэхэд нь хэрхэн нөлөөлдөг вэ?

Үр ашиг болоод урамшуулал

- ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрхөд болоод олон нийтэд үйлдвэрлэлийг хэн хянадаг вэ?
- Үйлдвэрлэл эрхэлсэний цалин хөлс, үр шимийг хэн хүртдэг вэ?
- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн цалин хөлс ялгаатай юу? Тиим бол яагаад?
- Аж ахуйн болон өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хэн зарж борлуулдаг вэ?
- Янз бүрийн эх сурвалжаас олсон орлогод хэн хяналт тавьдаг, ХАА-н үйлдвэрлэл эрхэлж байгаа өрхөд хэн нь юу авахыг хэн шийддэг, хэр орлогыг хүлээж авдаг вэ?
- Ямар хөрөнгө оруулалт, эсвэл зардалтай холбоотой шийдвэр гаргахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүд оролцдог уу?

Хүртээмж болон хяналт

Нөөц

- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцоо, эзэмших байдал хэр зэрэг байна вэ?
 - Газар, усны тоног төхөөрөмж, мал сүрэг, шувуу, загас, ой мод,
 - Хөрөнгө, зээл, мөнгөн болон биет хадгаламж /гар урлалаа борлуулж олсон албан бус орлогын эх үүсвэр гэх мэт/
 - Хөдөлмөрлөх /хүүхэд багачууд, гэр бүл, бусад төрөл төрөгсөд, албан бус ажлын бүлэг, хөлсний хөдөлмөр/
 - Үйлдвэрлэлд оролцох, ургац хураасны дараах хэрэглээ, ахуйн ажил хөдөлмөр
 - Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгсэл /бордоо, үр, дархлаажуулах тарилга/
 - Гар урлалын үйлдвэрлэлийн түүхий эд
 - Тээвэр
- Зарчмын хувьд болон бодит байдал дээр эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд доорх үйлчилгээнүүдийн хүртээмж ямар вэ?
 - Өргөтгөсөн үйлчилгээ
 - Албан ёсны хадгаламж, зээл, банкны үйлчилгээ
 - Албан бус хадгаламж, зээл, даатгал, үйлчилгээ/ байгууллагууд
 - Дадлага олгох сургалт/ түүний дотор нягтлан бодох
 - Бүртгэл
 - Үйлвэрлэл явуулах орон байр
 - Борлуулалт
 - Хоршоод, тэдгээртэй төстэй төрийн болон төрийн бус холбоод /өөрсдийн нэрээр, санал өгөх эрхтэй жинхэнэ гишүүнээр элсэх/
 - Мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны хэрэгсэл

ЗӨВЛӨМЖ

Тусгайлан
эмэгтэйчүүдэд
хандсан
харилцааны
стратегийг
анхаарч үзэх

→ Зарчмын хувьд болон бодит байдал дээр доорх зүйлст эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил хүртээмжтэй юу?

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- Ус болон ариун цэвэр
- Нийгмийн үндсэн дадлага олгох сургалт
- Боловсрол, бичиг үсэгт тайлагдах, тоо бодож сургах хөтөлбөрүүд

Өргөтгөсөн үйлчилгээ, дадлага олгох сургалт, борлуулалт, тоног төхөөрөмж, болон үр, бордоо гэх мэт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгсэл зэргийг эмэгтэйчүүдэд ижил хүртээмжтой болгох асуудлыг авч үзэх

Үр ашиг

→ Эрэгтэй, эмэгтэй хүмүүс үйлдвэрлэлийн үйл явцаас материаллаг болон материаллаг бус ямар ашиг хүртдэг вэ?

- Цалин хөлс /мөнгөн болон биет/
- Бүтээгдэхүүний борлуулалтын орлого
- Үйлчилгээний борлуулалтын орлого
- Бусад хэрэглэгдэхүүн /дайвар бүтээгдэхүүн гэх мэт/
- Нийгмийн даатгал /өвчтэй үеийн, өндөр насны гэх мэт/
- Харилцан туслалцаа
- Эрх хэмжээ, хүндэтгэл

→ Эмэгтэй, эрэгтэй хүмүүс олсон ашгаа ар гэрийнхэнтэйгээ хэрхэн хуваалцаж байна вэ ?

→ Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ямар зардлын хэлбэрүүд байдаг вэ ?

Бүтцийн болон нийгэм-соёлын хүчин зүйлсийн дүн шинжилгээ

Энэ дүн шинжилгээ нь төслийн үйл ажиллагааны жендэрийн байдалд болон төслийн хүртээж, хяналт удирдлагад нөлөөлж буй бүтцийн болон нийгэм, соёлын хүчин зүйлүүдийг судалдаг:

- Хүн ам зүйн хүчин зүйлс, өрхийн бүтэц, өрх гэрийг хэн толгойлж байгаа
- Ядуурлын түвшин, инфляцын хэмжээ, орлогын хуваарилалт, худалдааны дотоод нөхцөл, болон дэд бүтэц зэрэг эдийн засгийн ерөнхий нөхцлүүд
- Соёлын болон шашны хүчин зүйлүүд,
- Боловсролын түвшин, жендэрийн оролцооны хувь хэмжээ, болон
- Улс төрийн, нийгмийн тогтолцооны, хууль эрх зүйн хүчин зүйлс

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийг

дайчлан

оролцуулахын

тулд

эмэгтэйчүүдийн

төрийн бус

байгууллагуудтай

хамтран ажиллах ,

гэрээ байгуулах

Дүн шинжилгээ доорх зүйлсийг анхаарах ёстой:

- Эмэгтэйчүүдийн оролцоог хангах ямар бодлого, хөтөлбөрүүд төсөлд нөлөөлж болох вэ? Тэдгээр бодлого, хөтөлбөрүүд дараах зүйлсийг хамрана. Тухайлбал,
 - Хөдөө аж ахуйн яамд/ департамент болон орон нутгийн албад бүх түвшний сургалтын албад
 - Хэрэгжүүлэгч агентлагууд
 - Хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг төрийн бус болон судалгааны байгууллагууд
 - Хөдөө аж ахуйн ажлын дадлага эзэмшүүлдэг сургалтын байгууллагууд
 - Хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэшсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Эмэгтэйчүүд төсөлд оролцоход соёлын ямар хэм хэмжээ саад учруулдаг вэ?

- Төслийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцоонд олон нийтийн мөрддөг ямар хэм хэмжээ, итгэл үнэмшил нөлөөлдөг вэ? Тэдгээр хэм хэмжээ, итгэл үнэмшилд дараахийг хамруулж болно:
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцуулдаггүй соёлын тусгаарлалт
 - Нөхөн үржихүйд түлхүү оролцуулдаг
 - Олон нийтийн ажиллагаанд идэвхтэй оролцохоос тусгаарладаг
 - Үйлчилгээний ажилтай эрэгтэйчүүдтэй харьцахаас тусгаарлагддаг
 - Соёлын хэм хэмжээнээс шалтгаалан зорчиж явдаггүй байх

Эмэгтэй хүн тухайн чиглэлээр ажилладаг бусад эмэгтэйчүүдийн сүлжээнээс дэмжлэг авдаг уу?

- Төслийн эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж буй хууль эсвэл дүрэм журам байна уу?
- Өв залгамжлах хууль
 - Газар өмчлөх эрхийг зохицуулдаг журам
 - Зээлийн зохицуулалт /эрэгтэй халамжлагч батламжлах байдлаар хамт гарын үсэг зурах буюу газрын өмчлөх эрхээр барьцаалах эсвэл аль алиан нь хамт хийгдэх/
 - Хөдөлмөрийн хууль /хөдөө аж ахуйн эдэлбэр газарт, хөдөө аж ахуйд суурилсан үйлдвэрлэл байж болно/ буюу,
 - Соёлын онцлог

Төслийн үечлэлд хийх дүн шинжилгээ, Төсөл боловруулахад анхаарах асуудал

Энэхүү дүн шинжилгээ нь төслийн амжилттай хэрэгжих боломжийг дээшлүүлэх, төслөөс эмэгтэйчүүдэд учрах хохирлыг бууруулахын тулд төслийн бодит зорилго, арга барилыг өөрчлөх шаардлагатай эсэх, шаардлагатай бол чухам хэдийд өөрчлөхийг харуулдаг. Энэ дүн шинжилгээнд дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал,

Үйлдвэрлэл

- Төслийн үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийн хүнсний үйлдвэрлэлд оролцооноос хөндүүрүүлж байна уу ?
- Үр тарианы нэр төрөл өөрчлөгдсөнөөр эмэгтэйчүүдийн уламжлалт зах зээлд нөлөөлөх үү?
- Шинэ техник технологи эмэгтэйчүүдийн орлого олдог уламжлалт хөдөлмөрийг халж өөрчлөх үү?
- Төслийн үйл ажиллагаа эсвэл орлого эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх үү ?
- Үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, эрх тэгш байдалд нөлөөлөх өөрчлөлтүүдийг багасгахын тулд төсөл ямар нөхөн олговруудыг олгож болох вэ?

Сургалт

- Үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэгт нөлөөлж байгаа өөрчлөлтийг арилгах, эрх тэгш байдал, үйлдвэрлэлээс хүртэж байгаа ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн дадлага туршлагатай болгоход эмэгтэйчүүдэд зориулсан ямар сургалтыг төсөлд хамруулж болох вэ?
- Төсөл амьжиргаагаа залгуулахаас үйлдвэрлэл явуулдаг болон өөрчлөгдсөнөөр орлого нэмэгдэх гэх мэтээр үйлчлүүлэгчдийн амьдралын хэв маягыг өөрчлөх үү?
- Төслийн үр ашгийг хүртэхэд эмэгтэйчүүдэд ямар сургалт тусалж болох вэ?

ЗӨВЛӨМЖ

Хэрэгжүүлэгч
агентлагын
ажилтнуудад
жэндэрийн
мэдрэмжтэй
сургалт хийх

Төсөл эрэгтэй,
эмэгтэй
хүмүүсийн
өмчлөх
эрхийг хэрхэн
хангаж чадах
вэ?

- Эрүүл мэнд, нийгмийн хөгжил болон боловсролын байгууллагуудыг хамарсан салбар дундын нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломж бий юу?
- Сургалтад хамрагдаж, үр ашгийг нь хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусад нь сургах ёстой юу?
- Эмэгтэйчүүдийн бусад үүрэг, хариуцлагад нийцүүлж, тохируулах байдлаар сургалтын цагийг төлөвлөж болох уу?
- Жендэрийн тэгш байдлыг хангах, шийдвэр гаргахад үзүүлэх нөлөө, хяналтыг нь нэмэгдүүлэх /хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний сургалт/-ийн тулд эмэгтэйчүүдэд ямар сургалт олгож болох вэ?
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүст төслийн үр ашгийг ойлгуулж, хүртээхэд орон нутгийн үлгэр жишээ фермерүүд тусалж чадах уу?
- Төсөл бичиг үсэгт тайлагдаагүй эмэгтэй, эрэгтэй хүмүүст зориулсан харилцааны стратеги, шинэлэг арга барилыг нэвтрүүлэх талаар төсөл үйл ажиллагаа явуулах шаардлагатай юу?
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд жижиг бизнесийн удирдлагын, нягтлан бодох бүртгэлийн, үйлдвэрлэл эрхлэх дадлагын, маркетингийн зэрэг сургалтыг төслийн хүрээнд явуулж болох уу?

Мэдээлэл

- Мэдээлэл болон өргөтгөсөн үйлчилгээ эмэгтэйчүүдэд хүрч байна уу?
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шууд эмэгтэй, эрэгтэйчүүдэд хүргэж байна уу?
- Төслийн тухай мэдээллийг эмэгтэйчүүдэд хүргэхийн тулд харилцааны тусгай стратеги боловсруулах хэрэгтэй юу? /эмэгтэйчүүдийн өөр хоорондын мэдээлэл солилцоо эсвэл орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгийг ашиглах гэх мэт/
- Төслийн талаархи ойлголтыг түгээхдээ соёлын хувьд зүй зохистой, жендэрийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжихүйц байдлаар төлөвлөсөн үү?

Оролцоо

- Төслийн зорилтуудыг тодорхойлоход эмэгтэйчүүдтэй зөвлөж, тэднийг оролцуулсан уу?
- Төслийг төлөвлөж, боловсруулахад эмэгтэйчүүдийг оролцуулсан уу?
- Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад эмэгтэй оролцоогүй бол төслийн хүрээнд олон нийтийн бүлгийн хөгжүүлэх гэх мэт ухуулан таниулах арга хэмжээнд тэднийг оролцуулж болох уу? Энэ ажилд төрийн бус байгууллагуудыг оролцуулах боломж бий юу?
- Төсөлд эмэгтэйчүүдийг хамран оролцуулах талаар төрийн бус байгууллагуудыг гэрээгээр ажиллуулж болох уу?
- Зорчих шилжин суурьших асуудал эмэгтэйчүүдийг төсөлд оролцоход нь бэрхшээл үүсгэдэг бол төсөл эл бэрхшээлийг даван туулах үйл ажиллагааг төслийн хүрээнд зохион байгуулж болох уу?
- Эмэгтэйчүүдийг оролцоог хөхүүлэн дэмжихийн тулд төсөлд урамшууллын хэлбэрүүд байж болох уу?

Хүртээмж

- Эмэгтэйчүүдийн газар эзэмших, ашиглах, зээл авах, хоршоололд элсэх, бүтээгдэхүүнээ борлуулах, төлбөрөө авахад саад тотгор учруулдаг хуулийн заалтуудыг төслийн нөхцлүүдийн хүрээнд шийдвэрлэж чадах уу?
- Эмэгтэйчүүдийн өмчлөх эрх тэгш бус байх тохиолдолд эмэгтэйчүүдийн тэгш эрхийг төслийн хүрээнд нэмэгдүүлж чадах уу? /Хэрэв газрын шинэ гэрээ хэлцэл хийгдэхэд газар эзэмших эрхийг өрхийг толгойлж буй эрэгтэй эсвэл эмэгтэйн нэр дээр, өрх толгойлсон эмэгтэйн хувьд түүний нэр дээр хийхийг төсөл шаардаж болох уу?/
- Төслийн үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар оролцдог эмэгтэйчүүдэд материаллаг оролцоо болон үйлчилгээг үзүүлэх талаар өргөн хүрээтэй зорилт дэвшүүлж болох уу?

Төслийн
ажиллагааны
шалгуур үзүүлэл-
түүдийг жендэрээр
ялгавартай салгаж
боловсруулсан уу?

ЗӨВЛӨМЖ

Сургалтыг
явуулахдаа
эмэгтэйчүүдийн
шилжин
суурьших талаар
учирдаг
хүндэрлийг авч
үзэх

Тогтолцоог бэхжүүлэх нь

- Техникийн туслалцааны хөтөлбөрт эсвэл төсөлд доорх зүйлсийг хамруулах боломжтой юу?
 - Төсөлд эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмжих, төслийн эмэгтэйчүүдэд үзүүлэх төслийн үр дүнд мониторинг хийх боломжийг хэрэгжүүлэгч агентлагт олгохын тулд жендэрийн төлөвлөлт, жендэрийн бодлогын талаар сургалт явуулах уу?
 - Төслийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд төслийн хэрэгжилтийн явцад жендэрийн болон хөгжлийн талаарх зөвлөхийг авч ажиллуулах уу?
 - Хөгжлийн оролцооны асуудлаар сургалт явуулах /зорилт болон үйл ажиллагааг тодорхойлоход олон нийтийн оролцоог хангах арга замууд гэх мэт/
 - Өнөөгийн жендэрийн мэдээллийн сан нь хангалтгүй бол шинээр бий болгож, хөгжүүлэх

Төслийн цар хүрээ

- Эмэгтэйчүүдийг хөтөлбөрт оролцоход учирдаг бэрхшээл /жишээ нь төлөвлөлтийн хүрээний эсвэл логик хүрээний түвшин тус бүрд/-ийг төслийг боловсруулах, төлөвлөлтийн үе шатанд тодорхой гаргаж харуулдаг уу?
- Төслийн шалгуур үзүүлэлтүүд нь жендэрийн ялгавартай тоо баримтыг цуглуулах шаардлагтай гэдгийг харуулдаг уу? Жендэрийн хөдөлмөрийн хуваарийн өөрчлөлтөд мониторинг хийгддэг үү? Эмэгтэйчүүдийн нөөцөөс хүртэх, түүнд тавих хяналтын талаарх тоо баримт, мэдээллийг төслийн явцад цуглуулах уу?
- Төсөл жендэрийн практик хэрэгцээ /эмэгтэй, эрэгтэйчүүдийн үйлдвэрлэлд оролцох үүрэг, оролцоог сайжруулах, дэмжлэг үзүүлэх/-ний болон стратеги /төсөлд эмэгтэйчүүдийг оролцуулах замаар жендэрийн тэгш байдлыг сайжруулах/-ийн эрэлт хэрэгцээг хангаж чадах уу ?
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, чиглэл эмэгтэйчүүдэд холбогдолтой, эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээ, тэргүүлэх зорилтуудыг тусган харуулж байна уу ?

- Хөтөлбөрийн удирдлагад, бараа, үйлчилгээг хүргэх, удирдахад, тогтолцооны төлөвлөгөөт өөрчлөлтөд, сургалтын боломжид хөрөнгө мөнгө, ашиг тусын мониторинг хийхэд эмэгтэйчүүдийг оролцуулах боломжийг төслийн оролцоо тодорхойлох уу? Төслийн хөрөнгө хувь хүн, газар орон, цаг хугацааны хувьд ядуу эмэгтэйчүүдэд тохиромжтой бөгөөд хүртээмжтэй юу?
- Төсөл жендэрийн болон хөгжлийн зорилтууддаа хүрэх, хэмжиж болохуйц мониторинг үнэлгээний шалгууруудыг багтаасан уу ?

Хөдөө аж ахуйн зориулалтаар газар өмчлөх, ашиглахын тулд эмэгтэйчүүд хуулийн дагуу ямар эрхтэй байх ёстой вэ?

Дэд салбарууд дахь жендэрийн дүн шинжилгээ

Удиртгал

Зээл авахад эмэгтэйчүүдэд ямар бэрхшээл учирдаг вэ?

Өмнөх бүлэгт үзсэн хөдөө аж ахуй салбар дахь жендэрийн дүн шинжилгээний хүрээг хөдөө аж ахуйн дэд салбарууд дахь төслүүдийн жендэрийн дүн шижилгээг хийхдээ мөн хэрэглэвэл зохино. Нийгэм соёлын дүн шинжилгээ, төсөл боловсруулах, төлөвлөхтэй холбоотой асуудлууд, төслийн бүх шатны холбоотой нийтлэг асуудлуудыг анхан шатны үйлдвэрлэлийн салбарт оруулна.

Дэд салбарын дараахи жагсаалт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйл ажиллагаа, жендэрийн ялгавартай хүртээмж, удирдлагын хэлбэрүүдийн хувьд анхаарвал зохих асуудлуудыг дэвшүүлж байгаа юм.

Усжуулалтын салбар дахь жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Усны ашиглалт хийгээд усжуулалтын цаашдын эрэлт хэрэгцээний хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүс дараах зүйлс дээр ялгаатай ханддаг уу?
 - Усжуулалтад хамрагдах үр тарианы төрөл /арилжан худалдах болон хоол хүнсэнд хэрэглэх үр тариа гэх мэт/
 - Хөдөө аж ахуйн бус зориулалттай усны хэрэгцээ
 - Ус хэрэглэх шаардлагатай газар
 - Усны эх үүсвэрээс алслагдсан байдал /гэр орон болон тариалангийн талбай/
- Хөдөө аж ахуйн мэргэшилтэй эмэгтэйчүүдэд усжуулалтыг ашиглах хэрэгцээ байна уу?

- Усжуулалтын дүнд эрчимжсэн үйлдвэрлэл эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ? /ажлын шаардлага болон хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтад бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээ өөрчлөгдөх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хуваарилалтыг дагалдан гарах өөрчлөлтүүд/
- Үр тариаг ашиглах хэв загвар /арилжааны болон амьжиргааны үр тарианы үйлдвэрлэл /өөрчлөгдөх нь эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ?
- Хэрэгжилтийн шатанд үүсч болох олон цагаар ажиллах, эсвэл үйлчилгээний эрэлт өсөх нь эмэгтэйчүүдэд яаж нөлөөлөх вэ?
- Усыг зөв зохистой хэрэглэх менежментийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцдог уу? Усны менежментээс үүдэн гарах зөрчил маргааныг шийдвэрлэхэд тэд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- Ус хэрэглэгчдийн холбоод байдаг уу? Эмэгтэйчүүд тэдгээр холбоодод гишүүнээр элсэх боломжтой юу?
- Ус хэрэглэгчдийн холбоодод эмэгтэйчүүд гишүүд бий юү?
- Жендэр болон хөгжлийн асуудлыг төслүүдэд хамруулж хэрэгжүүлэх талаар хэрэгжүүлэгч агентлагуудын чадавх ямар байна вэ?
- Хэрэгжүүлэгч агентлагуудад эмэгтэй ажилтнууд бий юү?

Гол стратегиуд

- Төсөлд хамрагдах нутаг орон дахь усны хэрэглээний болон ус хэрэглэгчдийн ялгааг авч үзнэ үү. Усны хэрэглээ болон ус хэрэглэгчдийн хооронд үүсч болох зөрчлөөс зайлсхийх аргуудыг багтаах.
- Хөдөө аж ахуйн улиралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн онцлог хэрэглээний бэрхшээлийг даван туулах усны системийн төлөвлөлтийг сайжруулах
- Усжуулалтын зориулалтаар биш ашиглах усны хэрэглээ, ус хэрэглэгчдын эрэлт шаардлагыг хангах өртөг зардал багатай заалтуудыг төсөлд тусгах /мал аж ахуй, загас үржүүлэх цөөрөм, угаалга,

- цэвэрлэгээ, ахуйн хэрэгцээний хүнсний ногооны талбай, ундны ус гэх мэт/,
- Газар боловсруулах арга өөрчлөгдсөнтэй усжуулалт холбоотой эсэх, газрыг эрэгтэйчүүдтэй хамтран эзэмшигч болоход нь эмэгтэйчүүдэд туслах
 - Төслийн төлөвлөлтөд болон усны суваг шуудуу, бусад дэд бүтцийн байршилд холбоотой шийдвэрт эмэгтэй, эрэгтэй хэрэглэгчдийг оролцуулах
 - Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангасан төсөл боловсруулж хэрэгжүүлэх Хэрэгжүүлэгч агентлагуудын чадавхийг хөгжүүлж, бэхжүүлэх асуудлыг авч үзэх
 - Төслийн төлөвлөлтөд оролцуулахын тулд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн давуу талуудыг тодорхой тусгах
 - Ус хэрэглэгчдийн холбоодод эмэгтэйчүүдийг оролцуулах

5 дугаар хайрцаг

Усжуулалтын менежментийг шилжүүлэх Балбын төсөл

КЕЙС СУДАЛГАА

Тогтвортой бөгөөд үр дүнтэй ажиллаж чадах ус хэрэглэгчдийн холбоо байгуулах, усжуулалтын тоног төхөөрөмж, суваг шуудуунуудыг сэргээн засварлаж сайжруулах замаар Балбын ядуу тариачдад туслахад энэхүү төсөл чиглэсэн болно. Эл төсөл 67.800 га газрыг хамарсан 11 дэд төслөөс бүрдэнэ. Балбад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд болон усжуулалтад эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч эмэгтэйчүүдийн үүргийг ямагт дутуу үнэлж ирсэн бөгөөд хөдөө аж ахуйн хөгжлийн үр шимийг хүртэх боломж тэдний хувьд хомс байсан. Тийм учраас төслийн хэрэгжилтэд болон ус хэрэглэгчдийн холбоод /УХХ/-од эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд голлон анхаарсан байна.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд бодлогын болон төслийг хэрэгжүүлэх түвшинд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд Усжуулалтын Газар УХХ-д эмэгтэйчүүдийг оролцуулах талаар бодлогын болон тогтолцооны хоорондох зөрүүг ойлгуулах зорилгоор удирдах албан тушаалтнууддаа зориулан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан байна. Усжуулалтыг сайжруулах зорилгоор жендэрийг усжуулалтын асуудалтай холбон авч үзэж мужуудын усжуулалтын газрын ажилтнуудыг сургалтанд мөн хамруулсан аж. УХХ-дын ажиллагаа, удирдлагад илүү олон эмэгтэйг эрэгтэйчүүдийн хамт хамруулахад

- Ус хэрэглэгчдийн холбоодод эмэгтэйчүүдийг хамруулах зорилт дэвшүүлэх-Ус хэрэглэгчдийн болон усны менежментийн байгууллагуудад оролцуулахын тулд эмэгтэйчүүдийг дайчлах, сургах талаар төрийн бус байгууллагуудыг гэрээгээр ажиллуулах асуудлыг авч үзэх
- Ус хэрэглэгчдийн холбоодын гишүүнчлэл газрын өмчлөлд тулгуурлах тохиолдолд газрын өмчлөх эрхийг өрхийн тэргүүн болон эзэгтэйн нэр дээр хамтруулан олгох боломжийг эрэлхийлэх
- Хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч байгууллагуудад эмэгтэй ажилтан цөөн байх тохиолдолд орон нутгаас эмэгтэйчүүдийг ажиллуулах асуудлыг анхаарах

5 дугаар хайрцагт усжуулалтын салбар дахь жендэрийн асуудлууд хийгээд төслийн хүрээнд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж болох талаар үзүүлсэн болно.

дээрх семинари болон сургалтууд үр дүнгээ өгсөн байна. Эрэгтэй, эмэгтэй фермерүүдэд зориулан жендэрийн болон хөгжил /ЖХ/-ийн асуудлаар сургалтын нэгжийг байгуулжээ.

Төслийн өдөр тутмын үйл ажиллагаагаар дамжуулан жендэрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд ЖХ стратегийг боловсруулсан. Төслийн агрономич, социологчоор эмэгтэй мэргэжилтнүүдийг авч ажиллуусан бөгөөд УХХ-нд эмэгтэйчүүдийн оролцоог 20 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн. Төрийн усжуулалтын бодлогыг зохистой хэрэгжүүлэх нөхцлийг хангах, төслийн ажилтнуудыг сургахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жендэрийн мэргэжилтнийг авч ажиллуулсан байна. Ус хэрэглэгч эмэгтэйчүүдийг идэвхжүүлэхээр төслийн ажилтнаар эмэгтэйчүүдийг авч, ус хэрэглэсний төлбөрийг хэрэглэгчдээс хурааж цуглуулах ажлыг мөн эмэгтэйчүүдийн бүлэгт хариуцуулсан байна. УХХ-г тэргүүлэх эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгсэл, шинэ техник технологийг эмэгтэй гишүүдэд эзэмшүүлэхийн тулд тэдэнд сургалт зохиосон байна.

Жендэрийн асуудлыг эн тэргүүнд тавихад дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн төсвийг зүйл нэг бүрээр нарийвчлан гаргаж, мониторинг болон үнэлгээний зориулалтаар жендэрийн ялгавартай мэдээллийн санг бий бологх ажлыг төлөвлөөд байна.

Загас агнуурын салбар дахь жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Загас агнах, боловсруулах, зарж борлуулахад эрэгтэйчүүд, хөвгүүд, эмэгтэйчүүд, охид ямар үйл ажиллагааг гүйцэтгэдэг вэ? Загасыг боловсруулахын тулд эмэгтэйчүүд өөрсдөө агнадаг уу эсвэл худалдан авдаг уу? Эсвэл тэд өрхийн эрэгтэй гишүүдийнхээ барьсан загасыг боловсруулдаг уу?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар үйл ажиллагааг хамтран гүйцэтгэдэг вэ?
- Тусдаа болон хамтран гүйцэтгэх ажлуудад зарцуулах цаг хугацаа, улирлын хувьд ялгаа байдаг уу?
- Төсөл эдгээр ажиллагааны аль нэгэнд болон эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний орлогын өсөлтөд нөлөөлдөг үү?
- Төсөл эмэгтэйчүүдийн ажлын цагийн ачааллыг нэмэгдүүлдэг үү? Тийнхүү нэмэгдүүлэх нь тэдэнд ашигтай юу эсвэл хохиролтой байдаг уу?
- Эмэгтэйчүүд загас боловсруулах газруудад хөлсний ажилчнаар ажилладаг уу эсвэл өөрсдөө боловсруулах ажлыг эрхэлдэг үү /өөрөө худалдан аваад боловсруулж борлуулах зэрэг/ үү?
- Эмэгтэйчүүд байнга загасчилдаг уу эсвэл энэ нь улирлын чанартай үйл ажиллагаа байдаг юм уу?
- Зах дээр загас борлуулах нь эмэгтэйчүүдийн байнга эрхэлдэг хөдөлмөр үү эсвэл өрхийнхөө орлогыг нэмэгдүүлэх нэмэлт эх үүсвэр үү?
- Эмэгтэйчүүд загасаа зуучлагчдаар дамжуулж борлуулдаг уу эсвэл өөрсдөө шууд борлуулдаг уу?
- Загас наймаалдаг эмэгтэйчүүдэд зах дээр бараагаа борлуулах байнгын байр, зөвшөөрөлтэй байдаг уу?
- Эрэгтэй, эмэгтэйчүүдэд загас агнах хэрэгсэл, завь, загасны тор байдаг уу эсвэл зуучлагчид эсвэл наймаачдад ханддаг уу ?

ЗӨВЛӨМЖ

Загас агнуурт

эмэгтэйчүүдийн

гүйцэтгэдэг үүргийг

харгалзан үзэж

анхаарах

- Загас борлуулдаг эмэгтэйчүүд хөрөнгө мөнгөний хувьд хувиараа мөнгө зээлдүүлэгч нарт найддаг уу эсвэл зээлд хамрагдах албан ёсны эх үүсвэр байдаг уу?
- Хангалттай хэмжээний загас агнахад хүрэлцэхүйц дадлага туршлага эрэгтэй, эмэгтэй загасчдад байдаг уу?
- Эрэгтэй, эмэгтэй загасчид нийтийн эзэмшилд хамаардаг эх газрын усанд загас агнах эрхтэй юу?
- Ядуу эрэгтэй, эмэгтэй загасчид нуур, гол, цөөрөм зэрэг эх газрын усыг түрээсээр эзэмших боломжтой юу? Тэр боломж нь хязгаарлагдмал уу?
- Цөөрмийн загас агнуурт эмэгтэйчүүд оролцдог уу?
- Тэнгисийн болон эх газрын загас агнуурт загас барих, боловсруулах, борлуулах ажиллагаанд тогтсон жендэрийн хөдөлмөрийн хуваарийг төслийн үйл ажиллагаа өөрчлөж чадах уу?
- Зогсоол, боловсруулах үйлдвэрийн байршилд төсөл нөлөөлөх үү? Энэ нь тус салбарын эмэгтэй ажиллагсдад хэрхэн нөлөөлөх вэ ?

Гол стратегиуд

- Эмэгтэйчүүдийн оролцоо, үйл ажиллагаанд тавьдаг хяналтыг бууруулахгүйгээр зарцуулж буй цаг хугацаа, хөрөнгө мөнгөний хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйл ажиллагааг илүү эрчимтэй болгох арга замыг боловсруулах
- Төслөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ердийн үйл ажиллагаанд, эмэгтэйчүүдийн оролцооны түвшинд, эмэгтэйчүүдийн орлогод учирч буй сөрөг нөлөөллийг арилгах буюу багасгах арга хэмжээг тусгах
- Ургац хураасны дараах үед туслах, тэтгэлэг олгох талаар төслийг төлөвлөх, төслийн явцад анхаарах
- Загас агнуурын салбарт эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувь нэмэр, оролцоог дэмжих талаар бүрэлдэхүүн хэсгүүдийг бий болгох

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын уламжлалт хамтын ажиллагаа, бие биедээ харилцан тусалдаг байдлыг төсөлд тусган илэрхийлж, улмаар бэхжүүлэх боломжийг бүрдүүлэх
- Төслийн хүрээнд шинэ техник технологи /завь, тоног хэрэгсэл гэх мэт / олгох, ур чадвар эзэмшүүлэх сургалтанд эмэгтэйчүүдийг хамруулахад анхаарах
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс тус тусдаа санхүүгийн үүрэг, хариуцлага хүлээдэг тохиолдолд эмэгтэйчүүдийн орлогын эх үүсвэрийг хамгаалах, тэдэнд орлогын шинэ эх үүсвэр бий болгох боломжийг бүрдүүлэх
- Төслийн хүрээнд байгуулагдах эсвэл дэмжигдсэн бүлэг, бусад хэлбэрийн хамтын ажиллагаанд оролцох бололцоог эмэгтэйчүүдэд олгох
- Далайн болон эх газрын усанд загас агнах, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн уламжлалт эрх, загас агнаж орлого олох боломжийг бий болгох талаар төслийн үйл ажиллагааг төлөвлөх
- Төслийн хүрээнд арилжааны загас агнуур багтах тохиолдолд арилжааны загас агнуур нь загас боловсруулах, боловсруулахад эмэгтэйчүүдийн оролцоог бууруулахгүй байх нөхцлийг хангах
- Эрэгтэй, эмэгтэй загасчдад албан ёсны зээл, загас агнуурын хэрэгсэл, зах зээлд адил тэгш боломж олгох байдлаар төслийн бүрдэл хэсгүүдийг боловсруулах
- Төслийн үйл ажиллагаа нь загас агнуур, борлуулалт, боловсруулалтын орлогоос эмэгтэйчүүдийн хувь хүртэх, захиран зарцуулах боломжийг бууруулахгүй байх нөхцлийг хангах
- Эмэгтэйчүүд зах дээр өөрийн байр, зах зээл болон боловсруулах үйлдвэр, усан зогсоолд байнгын зөвшөөрөл олгох асуудлыг төсөлд тусгах

**Загас
наймаалдаг
эмэгтэйчүүд зах
дээр загасаа
борлуулах лангуу,
зөвшөөрөлтэй юу?**

ЗӨВЛӨМЖ

«Ургац хураасны»

дараах үеийн

эмэгтэйчүүдийн үйл

ажиллагааг дэмжих

бүрэлдэхүүн хэсгийг

төсөлд оруулах

- Загас агнуурын уламжлалт арга барилаа сайжруулах, шинэ арга ажиллагаанд суралцах боломжийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адил тэгш олгох үйл ажиллагааг төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх
- Худалдаачид, зуучлагчидтай наймаалцах боломжийг эрэгтэй, эмэгтэй загасчдад олгох үүднээс тэднийг нэгтгэсэн бүлгийг буюу байгууллагыг бий болгох

Филиппинд хэрэгжүүлсэн загас агнуурын төсөл жендэрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаархи кэйс судалгааг 6 дугаар хайрцагт харуулах болно.

6 дугаар хайрцаг

Филиппинийн Загас агнуурын баялагийн удирдлагын төсөл

КЕЙС СУДАЛГАА

Төсөлд Бэлтгэх Техникийн Туслалцаанаас үзэхэд загас агнуурт ялангуяа боловсруулах, борлуулахад эмэгтэйчүүд эдийн засгийн чухал үүрэгтэй оролцдог боловч энэ салбарын төсөл, хөтөлбөрүүдэд тэдний үүргийг хайхралгүй орхидог. Загасыг хэт олон тоогоор хэтрүүлэн агнадаг явдалд болон загас агнуурын ажлыг эрхэлдэг хүн амын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд сэтгэл түгшиж байдаг тул хамгаалах, тогтвортой удирдан зохион байгуулахад эрмэлзэж байдаг байна.

Төсөл дээр дурдсан сэтгэл түгшээсэн байдлыг залруулахын тулд эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж, загас хамгаалагчийн ажил олгож, байгаль орчинд хор хөнөөлтэй үйл ажиллагааны талаар мэдээллийг түгээх чадавхи, эрх мэдлийг олгож, эмэгтэйчүүдээр загас агнуурын холбогдолтой үйлдвэрлэл эрхлүүлэх үүднээс ихээхэн хэмжээний зээл олгосон аж.

Байгальд түшиглэсэн эко жуулчлал

Гол асуудлууд

- Аялал жуулчлалын улирлаар бараа болон хоол хүнс зарж борлуулах зэргээр эмэгтэйчүүдэд орлогын эх үүсвэр олох боломжтой юм уу? Хэрэв энэ боломжийг олгох бол эмэгтэйчүүдэд орлогын гол эх үүсвэр аль эсвэл нэмэгдэл эх сурвалжийг бий болгож байгаа юу? Эрэг хавийн нутгуудад аялал жуулчлалтай холбоотой ямар үйл ажиллагаа явагддаг вэ?
- Аялал жуулчлалын холбогдолтой төслийн үйл ажиллагаа нь эрэг хавийн нутгууд дахь эмэгтэйчүүдийн жижиг худалдаа хийх боломжийг багасгах уу?

Гол стратегиуд

- Арилжааны байгууллагууд болон төслийн үйл ажиллагаа нь жижиг худалдаачин эмэгтэйчүүдийг зах зээлээс шахан зайлуулахгүй байх нөхцлийг хангах, ингэж чадахгүй тохиолдолд орлого олох өөр үйл ажиллагаа явуулах боломжоор тэднийг хангах
- Байгаль хамгаалах чиглэлээр ажиллах боломжийг эмэгтэйчүүдэд олгодог эко-туризмыг хөгжүүлэх

Эмэгтэйчүүд байгаль хамгаалах чиглэлээр ажиллах боломжийг олж авах

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэй, эрэгтэйчүүдийн уламжлалт ажиллагаа, орлогод төслийн учруулах сөрөг нөлөөг арилгах арга хэмжээг авах

Ой модны болон усан хагалбарын менежмент дэх жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Төсөлд хамаарах орон нутийн ойн модны хэрэглээ болон холбогдох бусад үйл ажиллагаанд жендэрийн хөдөлмөрийн болон хариуцлагын хуваарь байдаг уу? Дараах зүйлсийг анхаарч үзвэл зохино:
 - Ахуйн болон өрхийн хэрэгцээнд ойн бүтээгдэхүүн бэлтгэх,
 - Түлшний мод бэлтгэх,
 - Гар урлал, арилжааны зорилгоор ойн баялагийг ашиглах
 - Суулгац, нялх модыг тарих, хамгаалах, арчлах,
 - Гэрийнхээ дэргэд мод тарьж, ургуулах, олон нийтийн болон төрийн мэдлийн газруудад тарих,
 - Ой болон модыг хэрэглэх хандлага, мэдлэг,
 - Ой, хөрс, модыг сүйтгэдэг практик ажиллагааг зогсоох,
 - Орлого олох, ажил эрхлэх боломж, болон
 - Жендэрийн тодорхой бүлгүүд хэрэглэдэг, ашигладаг модны төрлүүд

- Эмэгтэйчүүдийн эдгээр үйл ажиллагаанд оролцоонд төсөл нөлөөлөх үү?
- Ой модны төслийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд оролцоход цаг хугацааны, санхүүгийн, нийгмийн ямар хүндрэл учрах вэ? Жилийн янз бүрийн улиралд эдгээр нь харилцан адилгүй байдаг уу

ЗӨВЛӨМЖ

Ойг ашиглах эрэгтэй, эмэгтэйчүүдийн уламжлалт арга барилд үнэлгээ хийх

- Үнэлгээтэй хөдөлмөрт /шилжүүлэн суулгах, зэрлэг ургамлыг цэвэрлэх, ургамал үржүүлэгийн газрыг өмчлөх, тэдгээрт ажиллах/ эмэгтэйчүүдийн хөдөлмөр тооцогдож байна уу?
- Эмэгтэйчүүдийн ажлын өдөр, хөдөлмөр эрхлэх хэлбэрт төсөл нэмэлт ачаалал үүсгэх үү? Эдгээр нь эмэгтэйчүүдэд үр ашиг өгөх үү? эсвэл хохирол учруулах уу?
- Төсөл хэрэгжих газарт эмэгтэйчүүд өөрсдийн бараа бүтээгдэхүүний борлуултанд хяналт тавих боломжтой юу?
- Ой модыг эзэмших эрх хэнд байдаг вэ? Ой мод төрийн өмчинд байдаг уу? Ард түмний өмч үү эсвэл орон нутгийн өмчинд байдаг уу? Ой мод төрийн түрээсийн газар дээрх аль нэгэн олон нийтийн өмч үү? Ой мод нутгийн уугуул иргэдийн мэдлийн газарт байдаг уу?
- Олон нийтийн эсвэл орон нутгийн мэдлийн ойн газрыг хэн өмчилдөг вэ? Төрийн түрээсийн газар дээрх ойг хэн ашиглах боломжтой вэ? Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өмчилдөг үү? Уугуул иргэдийн мэдлийн ойг эрэгтэй, эмэгтэй хүмүүс өмчилдөг үү эсвэл бүхэлдээ нийт омог эсвэл олон нийтийн өмч үү?
- Ойн газрыг эмэгтэй, эрэгтэй хүмүүс өмчлөх эрхийн уламжлалт ямар хэлбэр байдаг вэ?
- Ойн бүтээгдэхүүнийг эмэгтэй хүн цуглуулах, ашиглахад нийгмийн зүгээс саад бэрхшээл учирдаг уу?
- Ойн бүтээгдэхүүнийг хэн хүртэх, цуглуулах, ашиглахыг өмчлөгчөөр дамжуулан шийдвэрлэдэг үү?
- Нийтийн эзэмшлийн газарт мод тарихад эмэгтэйчүүд хөлсөөр ажилладаг уу? Тэд тэрхүү тариалангаас түрээслэх эрх эдлэх боломжтой юу?
- Төсөл нь ойн бүтээгдэхүүнийг цуглуулах, ашиглах эмэгтэй, эрэгтэйчүүдийн уламжлалт эрхэд нөлөөлөх үү?

ЗӨВЛӨМЖ

Нийтийн мэдлийн
ойг хамтран
эзэмших эрхийг
олгох арга хэмжээг
нэвтрүүлэх

- Ойг ашиглах уугуул эмэгтэй, эмэгтэй иргэдийн эрхийг төсөл өөрчлөх үү?
- Шинээр мод тарих, дахин ойжуулах ажлыг төсөл эхлүүлэх үү? Тийм бол төслийн үйл ажиллагаа дараах зүйлст ямар нөлөө үзүүлэх вэ? Тухайлбал,
 - Эмэгтэй, эрэгтэйчүүдийн орлогын уламжлалт эх үүсвэрт
 - Ажил эрхлэх боломжид
 - Төрийн түрээсийн газрыг дахин ойжуулахад буюу шинээр тарихад
 - Нийтийн эзэмшлийн ойн ашгийн хүртэхэд

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийн
бусад үүрэг
хариуцлагад
тохирсон
сургалтыг
төлөвлөх

Гол стратегиуд

- Ойг ашиглах эмэгтэйчүүдийн уламжлалт эрх мэдлийн бууруулахгүй байх. Ойн модны хүртээмжийг дээшлүүлэх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ойн бүтээгдэхүүний ашиглалтын үр ашгийг дээшлүүлэхдээ эмэгтэйчүүдийн ойн бүтээгдэхүүнийг ашиглах, хүртэх, удирдах эрхийг бууруулахгүй байх нөхцлийг хангах
- Олон нийтийн, төрийн, орон нутгийн эзэмшлийн ойн баялагийн төсөл эрэгтэй, эмэгтэй хүмүүст адилхан хүртээмжтэй байх нөхцлийг хангах
- Өөр хоорондоо өрсөлддөг хэрэглээ, хэрэглэгч нарын болзошгүй зөрчлөөс зайлсхийх арга хэмжээг тусгах, ойг ашиглагчдад сөргөөр нөлөөлөхөөс зайлсхийх
- Нийгмийн/олон нийтийн ойд мод тарих, арчлах төсөлд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран ажиллах нөхцлийг хангах
- Эмэгтэйчүүдийн онцгойлон тарьдаг модныг ургуулах талаар төслийн үйл ажиллагаанд тусгах
- Арчлах арга ажиллагаа, мод тарих газрыг сонгох, модыг шилж сонгох, газрыг боловсруулж бэлтгэх, тарьж суулгах, зэрлэгээс цэвэрлэх, хамгаалах, үр өгөөжийг дээшлүүлэх гэх мэт шаардлагатай зүйлст эмэгтэйчүүдийг сургах

ЗӨВЛӨМЖ

Ой модыг
хамгаалах
чиглэлээр эмэгтэй
ажилтнуудыг сургах

- Дээрх оролцоо, шинэ техник технологийг эмэгтэйчүүдэд үр дүнтэй хүргэх арга замыг эрэлхийлэх
- Ойг өргөжүүлэх эмэгтэй ажилтнуудыг төслийн хүрээнд сургах ойг өргөжүүлэх ажилтнуудад эмэгтэйчүүдийн ойн модны хэрэглээ, ялангуяа эрэлт хэрэгцээг, хүндрэл бэрхшээлийг ойлгуулж мэдрүүлэх
- Ойн үнэ цэн, ойн баялагийг ашиглахад нөөцийг нь устгадаг зуршлыг халж, зохистой хандлагыг нэвтрүүлэх, ойн нөөцийг тогтвортой ашиглах, хөрсний элэгдэл, модны сонголт зэргийг хийхэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх
- Төрийн өмчийн газрыг түрээсээр эзэмших, замын хажуугийн ойд шинээр мод тарих, дахин ойжуулах ажилд эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн бүлгийг оролцуулах арга хэмжээг нэвтрүүлэх
- Нийтийн эзэмшлийн ойг эрэгтэй, эмэгтэйчүүдэд хамтран эзэмших эрх олгох арга хэмжээг нэвтрүүлэх
- Эмэгтэйчүүдийн ойн баялагийн менежментийн уламжлалт мэдлэг, нийгмийн ойн төсөлд болон орон нутгийн ойд мод сонгох арга уламжлалыг хэрэглэх
- Энэхүү төслийн хүрээнд олон нийтийн бүлэг, ойн баялагийн менежментийн хороо байгуулагдвал тэдгээрт эмэгтэйчүүдийг оролцуулах нөхцлийг хангах

Бангладеш улсын Сундарбанс дахь биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах төсөлд жендэрийн болон тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлсэн тухай кэйс судалгааг 7 дугаар хайрцагт өгүүлэх болно.

7 дугаар хайрцаг

Бангладеши улсын Сундарбанс дахь биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах төсөл

КЕЙС СУДАЛГАА

Сундарбансийн нөөц ой бол 6 мянган хавтгай дөрвөлжин километр талбайг хамран үргэлжилдэг, мангров хэмээх модтой дэлхийн хамгийн том талбай билээ. Сундарбансийн нөөц ой /СНО/ нь загас, сам хорхой, жигүүртэн шувуудаас гадна Бенгалийн бар зэрэг олон төрөл зүйлийн зэрлэг ан амьтан нутагладаг, ойр хавийн 20 километрийн голдочтой бүсэд нь 17 дүүргийн нийт 3.5 сая хүн амьдардаг бөгөөд тэдний хувьд ойн ашиг шимийг хүртэж амьдрал ахуйгаа залгуулдаг газар юм. Гэвч ойн баялагийг ашигладаг уламжлалт аргууд, тэдгээрийн түүж цуглуулдаг улирлын чанартай арга ажиллагаа нь бүхэлдээ алдагдсан байна. СНО үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэгчид, нутгийн оршин суугчид, загасчид, Бенгалийн буланд үйл ажиллагаа явуулдаг загас агнуурын хөлөг онгоцнууд ч уг газрыг ихээр ашигладаг болжээ. Ойн баялагийг хэрэглэгчдийн тоо ийнхүү эрс нэмэгдсэн, хэт үрэлгэн байдлаар ашиглах явдал даамжирсантай холбогдон загас, ой мод, биологийн төрөл зүйлийн нөөц нь шавхагдахад хүрсэн аж.

СНО-оос түлээний мод бэлтгэх, ойн баялагийг нь түүж цуглуулах ажлыг голдуу хийдэг байсан ойр тойронд нь нутагладаг эмэгтэйчүүдийн дунд ядуурал газар авсанаас тэд загас агнан болон хавч барьдаг болжээ. Сам хорхойны эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээс үйлдвэрлэл өргөжиж, түүнд эмэгтэйчүүд татагдан оролцдог болсон төдийгүй охид сургуулиас завсардаж, эрүүл мэнддээ халтай ажил эрхлэх, хүчирхийлэлд өртөх, гэмт халдлагад өртөхөд хүрсэн юм байна. Нийгмийн болон ойн захиргааны албан тушаалтнууд ойн баялагийг түүж цуглуулахад эмэгтэйчүүдийн оруулдаг хувь нэмрийг төдийлөн ойшоодоггүйгээс ойн менежментийн бодлогод тэдний эрх ашгийг огт анхаардаггүй болжээ.

Загас агнаж, сам хорхой түүдэг эмзэг амьдралтай айл өрхүүдийн эмэгтэйчүүд завь, загасны тор, амьжиргааны бусад шаардлагатай зүйлсээ олж авахын тулд хувь хүмүүс эсвэл сам хорхойн ченжүүдээс өндөр хүүтэй зээл авахад хүрдэг байна. Эмэгтэйчүүд ундны цэвэр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээгээр хомсдон өвчин эмгэгт олноор өртдөг болсон байна.

СНО биологийн төрөл зүйлийг хамгаалах төсөл нь зохистой төлөвлөлт, гол оролцогчдыг хамран оролцуулах замаар СНО-д тогтвортой менежментийг нэвтрүүлж, биологийн төрөл зүйлийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлэхийг зорьсон байна. СНО-н ногоон бүсэд нутагладаг 3.5 сая хүмүүсийн дунд СНО баялагийг ашиглагчдын олон нийтийн байгууллагыг эмхлэн байгуулж, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах боломжийг нь нэмэгдүүлэх, хоёрдогч ажил эрхлэх боломжийг бүрдүүлэх, нийгмийн дэд бүтцүүдийг боловсронгуй болгох ядуурлыг бууруулахыг гол зорилгоо болгосон аж. Төслийн олон нийтийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг жендэрийн асуудлаар зөвлөхийг авч ажиллуулан тус бүсэд амьдарч ойн баялагийг хүртдэг эмэгтэйчүүдийн эрэл хэрэгцээг хангах зорилт дэвшүүлсэн байна. Төслийн үр шимийг хүртэгчдийн тэн хагас нь ядуу зүдүү амьдралтай эмэгтэйчүүд байдаг учир өрх толгойлсон эмэгтэйчүүдэд нэн тэргүүнд анхаарлаа хандуулсан аж.

Төсөл СНО баялагийн менежментийн төлөвлөлтөд болон ногоон бүсэд явуулж буй өөрсдийн үйл ажиллагаа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар хамтран дуу хоолойгоо сонсгодог болгох зорилгоор СНО-н баялагийг ашигладаг эмэгтэйчүүдийг дайчлан, тэдний бүлгүүдийг зохион байгуулсан байна. Ойн баялагийг ашиглагч

(Үргэлжлэл дараагийн хуудсанд)

(Хайрцаг 7-ийн үргэлжлэл)

эмэгтэйчүүд, хамтын байгууллагаараа дамжуулан СНО-н баялагаас, ногоо бүсийн нийтийн баялагаас хувь хүртэх өөрсдийн эрхийг баталгаажуулах боломж бүрдсэн байна. Загасны нөөцийг тогтвортой байдлаар ашиглах, байгаль хамгаалах ухамсарыг төлөвшүүлэх, СНО-н баялагт зохистой менежмент хийхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрүүдийг мөн хэрэгжүүлсэн аж.

Төслийн хүрээнд хусны нүүрс бэлтгэх, суулгац тарих, дахин ойжуулах, эмэгтэйчүүдийг СНО-н баялагт болон сам хорхой түүхэд найддаг байдлыг өөрчлөн хоёрдогч ажлын байр бий болгох зорилгоор зээлийн хөтөлбөрийг эхлүүлсэн байна. Хувийн мөнгө зээлдүүлэгчдэд түшиглэдэг байдлыг өөрчлөх, орлогыг нь нэмэгдүүлэхийн тулд бичил зээлийн хөтөлбөрийг бас хэрэгжүүлсэн аж. Охидын сургуульд хамрагдах явдал ч сайжирах болжээ.

Байгалийн баялагийг ашиглах талаар эмэгтэйчүүдэд удирдах ажилтны сургалт явуулж, Зөвлөлдөх Хороонд өөрсдийн төлөөллийг ажиллуулан эмэгтэйчүүдийн бүлгийн эрх ашгийг хөндсөн асуудлаар дуу хоолойгоо гаргах, байгалийн баялагт цогц байдлаар менежмент хийх бодлого боловсруулахад Сундарбансийн удирдлагын нэгжтэй хамтран ажиллах боломжтой болсон байна

СНО-н ногоон бүсэд ундны усны байгууламж, биеийн засах газар, олон нийтийн сургууль байгуулах ажлуудыг байгалийн баялагийг ашиглагч эмэгтэйчүүдийн бүлэгтэй зөвлөлдөх, нийгмийн дэд бүтцийн төлөвлөлтөд эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцуулах нь олон нийтийг хамарсан асуудлаар шийдвэр гаргах тэдний чадварыг үнэлж байгаа хэрэг төдийгүй тэдгээр нийтийн байгууламжийг бидний өмч хэмээн үзэх хандлагыг тэдэнд бий болгоход тустай байжээ. Нийгмийн дэд бүтэц эмэгтэйчүүдийн амьдралын түвшинг дээшлүүлж тэдний үр хүүхдэд сурч боловсрох боломж олгосон байна.

Хөрөнгө мөнгө, орлого нэмэгдэн, сургалт, хамтын удирдлагын байгууллага хүртээмжтэй болсоноор эмэгтэйчүүд аажим аажмаар гэр бүлдээ байр суурь эзэлж, СНО-н нөөц баялагийн менежментэд улам тодорхой үүрэг гүйцэтгэдэг болж байна.

Эргийн нутгуудын удирдлага дахь жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Эрэг хавийн ойд эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүд ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ямар үйл ажиллагааг хамтран явуулдаг вэ?
- Эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүд ой мод руу байнга эсвэл хааяа явдаг уу?
- Эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүдийн хэн нь ойн баялагийн их эсвэл бага хэмжээгээр түүж ашигладаг вэ?

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ойн баялагийг түүж ашиглах уламжлалт ямар эрх эдэлдэг вэ?
- Айл өрхүүд ойн бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг уу эсвэл амьжиргаандаа хэрэглэдэг үү? Хэрэв худалдан борлуулдаг бол эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүд эсвэл эмэгтэй, эрэгтэйчүүдээс хэн нь борлуулдаг вэ?
- Эдгээр үйл ажиллагааны аль нэгэнд болонд өрхийнхөө амьжиргааг залгуулахад эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэг, тэдний мөнгөн орлогод төсөл нөлөө үзүүлэх үү?
- Эмэгтэйчүүдийн ажлын ачаалалд нөлөөлөх, орлого олох боломжийг боогдуулах үйл ажиллагааг төсөл явуулах уу?
- Эрэг хавийн нутгуудын эмэгтэйчүүдийн хэрэглээний уламжлалт эрх, нийтийн эзэмшилд багтдаг баялагийг тэдэнд хүртээмжтэй байлгахад төсөл нөлөө үзүүлэх үү? Хэрэв нөлөө үзүүлэх бол яаж, ямар үр дагаварт хүргэх вэ?

Гол стратегиуд

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ажлын ачаалал, орлого олох үйл ажиллагаа, амьжиргааны хэрэгцээ шаардлагад сөрөг нөлөө үл учруулах ажиллагааг явуулах
- Төслийн үйл ажиллагаа эмэгтэйчүүдийн ажлын нөхцөл, ажлын ачаалал, ажлын цаг хугацаанд сөрөг нөлөө учруулах байдлаар жендэрийн хөдөлмөрийн хуваарийг өөрчлөхгүй байх нөхцлийг хангах
- Ойн баялагийг ашиглах эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн уламжлалт эрхийг боогдуулалгүй, алдагдсан боломжийг нь тэдэнд нөхөн олгох хоёрдогч ажиллагааг бий болгохуйц үйл ажиллагааг төлөвлөх
- Байгууллагыг үүсгэн бий болгох, сургалт, хөрөнгө, маркетинг гэх мэт хөтөлбөрийн нөөц, тэдгээрийг захиран зарцуулах эрхийг эмэгтэй, эрэгтэйчүүдэд тэгш олгох төслийн бүрэлдэхүүн хэсгийг бий болгох

Төслийн шийдвэр
гаргахад эмэгтэйчүүд
оролцдог уу?

Хөдөө орон нутгийг цогцоор хөгжүүлэхэд анхаарах жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Төсөлд хамрагдах нутгийн хүн амыг жендэрийн ялгавартай байдлаар хүйсээр ангиллагдсан уу /хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, хүйсийн хөдөлмөрийн хуваарь, үйлдвэрлэлийн гол чиглэлээр зарцуулагддаг цаг хугацаа гэх мэт/?
- Төсөл хөдөө аж ахуй, загас агнуур, мал аж ахуй гэх мэт салбар дундын чиглэлээр хэрэгжих тохиолдолд хөдөө аж ахуй, мал аж ахуй, загас агнуурын салбарын хүйсийн хөдөлмөрийн хуваарийн талаарх жендэрийн ялгавартай байдлаар салган авсан тоо баримтуудыг цуглуулах уу?
- Үйлчлүүлэгч хүн амын дунд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоог гаргасан уу?
- Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг эмэгтэйчүүдийн үйл ажиллагаанд төсөл ямар нөлөө үзүүлэх вэ?
- Эмэгтэйчүүдийн эрхэлдэг газар тариаланд төсөл дэмжлэг үзүүлэх эсэх?
- Төсөлд хамрагдах нутаг нийгмийн ямар бүтэцтэй, газар, нийтийн баялаг, бизнес болон бусад баялагийн хүртээмж бүлгүүдэд ямар хэмжээтэй байдаг, тэдгээрт ямар бүлэг тавих хяналт тавьдаг?
- Эмэгтэйчүүд аж ахуйн бус орлогын өөр ямар үйл ажиллагааг эрхэлдэг вэ?
- Эмэгтэйчүүд өмчлөх эрхтэй эсэх, газар эзэмших эрхтэй эсэх?
- Төсөлд хамрагдах нутагт нийгмийн болон олон нийтийн ямар байгууллага ажилладаг эсэх, төсөл хэрэгжих нутагт хөгжлийн чиглэлтэй төслийн ажлыг эмэгтэйчүүдэд олгох зэрэг баялагийн хуваарилалтад хэрхэн хяналт тавьдаг вэ?
- Төсөл хэрэгжих нутагт эмэгтэйчүүдийн албан бус сүлжээ байдаг уу? Хэрэв байдаг бол эмэгтэйчүүдэд ямар дэмжлэг үзүүлдэг вэ?

- Албан ёсны байгууллагуудаас олгодог зээл, аж ахуйг өргөтгөх үйл ажиллагаа, газар тариалан болон мал аж ахуйн чиглэлээр хийх ажил эмэгтэйчүүдэд хүртээмжтэй эсэх?
- Эмэгтэйчүүд шаардлагатай ажилд нь хэрэгцээтэй хөрөнгийг хувиараа мөнгө зээлэгчид, худалдаачид, найз нөхөд, төрөл садангийнхаа хэнээс нь авдаг вэ? Эмэгтэйчүүд хувь мөнгө зээлдэгчид, худалдаачид, зуучлагчдаас өндөр хүүтэй мөнгө зээлдэг үү?
- Эмэгтэйчүүдийн бараа бүтээгдэхүүнийг хэн зарж борлуулдаг вэ? Худалдаачид, зуучлагчид эсвэл өөрсдөө юу?
- Жендэрийн хөдөлмөрийн хуваарь, амьжиргаа залгуулах ажил, эмэгтэйчүүдийн ажлын ачаалал, орлого олох үйл ажиллагаа, газар, мал сүрэг, нийтийн эзэмшлийн баялагаас тэдэнд хүртэх байдалд төслийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх вэ?
- Үйлчилгээг эмэгтэйчүүдэд хүргэх чадавхи хэрэгжүүлэгч агентлагт бий юу?

Гол стратегиуд

- Төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг төлөвлөх явцад жендэрийн ялгавартай байдлаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй тус тусад нь зөвлөлдөх, эмэгтэй, эрэгтэйчүүдийн нэн тэргүүний зорилтууд, эрэлт хэрэгцээ, эрмэлзэл төслийн хүрээнд тусгагдах нөхцлийг хангах
- Төсөл хэрэгжих нутгийн эмэгтэй, эрэгтэйчүүдийг төслийн төлөвлөлтөд хамран оролцуулах
- Эмэгтэйчүүдийн дэвшүүлсэн ус, ариун цэвэр, эрчим хүч, түлшний эрэлт хэрэгцээг шийдвэрлэх
- Төсөлд ундны усны асуудал хамрагдах тохиолдолд ус шахах шахуургыг суурилуулах газрыг сонгох, төлөвлөхдөө эмэгтэйчүүдийг оролцуулах, түүнийг ажиллуулах, засвар үйлчилгээг хийх сургалтад эмэгтэйчүүдийг хамруулах
- Төслийн үр шимийг түгээх систем эмэгтэй, эрэгтэйчүүд, аж ахуй эрхлэгчдэд хүрч байх нөхцлийг

ЗӨВЛӨМЖ

Төсөлд
хамрагдаж буй
нутгийн
олон нийтийн
байгууллагууд
баялагийн
хуваарилалт,
ялангуяа
эмэгтэйчүүдэд
хэрхэн ногдож
байгааг
тодорхойлох

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэй
оролцогчидтой
ажиллахдаа тэдний
нөхөр, ах дүүс зэрэг
эрэгтэй
зуучлагчдаар
дамжуулахаас
зайлсхийх

- хангах эмэгтэй туслах ажилчдын эрэлт хэрэгцээг анхаарах
- Аливаа сургалтыг эмэгтэй, эрэгтэйчүүдэд адилхан хүртээмжтэй байгах зорилт дэвшүүлэх талаар анхаарах
 - Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн тусгай бүлэг байгуулах асуудлыг авч үзэх
 - Эмэгтэй туслах ажилчдыг сургах хөтөлбөрийг төлөвлөн боловсруулах
 - Эмэгтэй оролцогчидтой ажиллахдаа /тэдний нөхөр, ах дүүс зэрэг/ эрэгтэй зуучлагчдаар дамжуулахаас татгалзах
 - Хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг төсөлд тусгах
 - Төслийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг эн тэнцүү оролцуулах тухай зүйл заалтыг төслийн төлөвлөлт болон дотоод бүрэлдэхүүнд суулгах
 - Хөдөө аж ахуй, загас агнуур, мал аж ахуй дахь жендэрийн хөдөлмөрийн хуваарийг эмэгтэйчүүдэд сөрөг байдлаар нөлөөлөхгүй байхаар хийх нөхцлийг хангах
 - Орлого олох үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн үүргийг төслөөр дамжуулан бататган бэхжүүлэх
 - Эмэгтэйчүүдийн бүлэг үүсгэн байгуулах, эмэгтэйчүүдийн амьдралд нөлөө үзүүлдэг асуудлуудаар ажиллахад одоогийн ажиллаж буй сүлжээнүүдийг бэхжүүлэх
 - Хөдөөгийн албан бус хэвшил /хөдөө аж ахуй, агробизнес, загасны аж ахуй, дэд бүтэц, барилгын ажил/-д хөдөлмөрлөдөг эмэгтэй ажилчид шударга цалин хөлс авдаг байх нөхцлийг бүрдүүлэх
 - Төслийн хүрээнд байгуулагдсан нэгдэл/ хадгаламж зээлийн хоршоод, бусад байгууллага эмэгтэй гишүүдтэй байх нөхцлийг хангах
 - Эмэгтэйчүүдийн гар урлал, өрхийн үйлдвэрлэлийг дэмжихэд зээл ашиглах, бизнес менежмент болон маркетингийн аргуудыг хэрэглэх
 - Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, орлогыг нь дээшлүүлэхийн тулд тэдний

бараа бүтээгдэхүүнийг хөхүүлэн дэмжих хоршоодыг байгуулахад анхаарах

- Төслийн бүх шатанд эмэгтэйчүүдийг идэвхтэй оролцуулах стратеги, механизмуудыг төслийн төлөвлөлтөд оруулж нөхцлийг хангах

Жендэртэй холбоотой дээр дурдсан гол асуудлуудыг орон нутгийг хөгжүүлэх төсөлд анхаарч хэрэгжүүлсэн тухай 8 дугаар хайрцгаас үзэж болно.

8 дугаар хайрцаг

Бүгд Найрамдах Киргиз Улсын хөдөө аж ахуйн хөгжлийн төсөл

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дээшлүүлж, ядуурлыг бууруулахад төслийг амжилттай хэрэгжихэд нөлөөлөх жендэрийн дүн шинжилгээг Төсөлд Бэлтгэх Техникийн Туслалцаа шатанд хийсэн. Ихээхэн газар авсан ажилгүйдэл, нийгмийн үйлчилгээний хомсдол, үлэмж цаг хугацаа шаарддаг өрхийн гишүүддээ тавих халамж анхаарал, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд тооны хувьд өссөн, хувиараа аж ахуй эрхлэгчдэд газрыг олгоходоо эмэгтэйчүүдийг орхигдуулдаг, шинэ үйлдвэрлэгчдэд болон маркетингийн зохион байгуулалтад үл ойшоогддог гэх мэт олон учир шалтгааны улмаас шилжилтийн үеийн эдийн засагт хамгийн ихээр хохирогсад бол хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд гэдгийг нийгмийн тандалт судалгаа, аж ахуйн нэгжүүдийн судалгаа харуулсан.

КЕЙС СУДАЛГАА

Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төсөл чиглэгдсэн бөгөөд шинэ хуулийн хүрээнд газар олгоход эмэгтэйчүүдэд хүртээж буй эсэхийг сайтар хянасан. Төслийн хүрээнд үүсч бий болсон аж ахуйн шинэ байгууллагуудад элсэн оролцох боломжийг аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд, ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүдэд жигд олгосон. Аж ахуй эрхлэх шинэ хэлбэрт нийцүүлж чадваржуулах, бизнесийн төлөвлөгөө боловсруулах, зээлд хамрагдах боломжийг эмэгтэйчүүдэд түлхүү олгох зорилгоор төслийн хүрээнд зохиогдох сургалтын хөтөлбөрүүдэд хамран оролцуулж ялангуяа аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг хөхүүлэн дэмжсэн.

Үр ашгийн мониторинг, үнэлгээ нь эмэгтэйчүүдийн газар өмчлөх, үйлдвэрлэгчдийн байгууллагуудад гишүүнээр элсэх, сургалтанд хамрагдах, сургалт нь эмэгтэйчүүдийн орлогыг эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад нэмэгдэх, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн нийгмийн байдалд зэрэг өөрчлөлтөнд чиглэгдсэн.

Бичил санхүүжилт дэх жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Зээлийг ашиглах байдал /зээлийн төрөл, зээлийн тоо, хүү, хувь хэмжээ, хугацаа дууссан өр, найдваргүй өр, зээлийн хэмжээ, үр ашигтай хэрэглээ гэх мэт/-аараа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ялгардаг уу?
- Үйлчилгээнд хамрагдах хүн амд аж ахуй эрхлэдэг, үйлдвэрлэл явуулдаг, үйлдвэрлэгч, ажилчин эсвэл өрх толгойлдог эмэгтэйчүүдийн тоо олон байдаг уу?
- Эмэгтэй, эрэгтэйчүүд тус тусдаа зээлийн хоршоод, хадгаламж зээлийн бүлэгтэй юу?
- Эмэгтэйчүүдэд зээл авах боломж эрэгтэйчүүдийнхээс хязгаарлагдмал байдаг уу? Энэ байдал нь эмэгтэйчүүдийн өмчлөх эрх, хариуцлага хүлээх чадварт хэрхэн нөлөөлдөг вэ?
- Зээл авах талаар өнөөгийн хэв загварыг төсөл өөрчлөх үү?

ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийн
дунд
удирдагчдыг
бэлтгэх,
сургалтыг төслийн
бүрдэл хэсгүүдэд
тусгах

Гол стратегиуд

- Төсөл хэрэв шинэ төрлийн хадгаламж, зээлийн бүлгүүдийг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн бол тэдгээрийг эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах нөхцлийг хангах
- Эмэгтэйчүүдийн хадгаламж, зээлийн бүлгүүдийг байгуулах
- Шинэ төрлийн хадгаламж зээлийн бүлгүүдэд эмэгтэйчүүдийг оролцуулахаар бодлогод болон хуулинд өөрчлөлт оруулах асуудлыг авч үзэх
- Эмэгтэйчүүдийг зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, хадгаламжийг хөхүүлэн дэмжих тусгай зүйл заалт оруулах /мэдээлэл, харилцааны болон сургалтын стратеги, ядуу эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн боломжийг нэмэгдүүлэх нөхцлийг авч үзэх/

- Бизнес эхлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бизнесийг хөтлөн удирдах, маркетингийн чиглэлээр эмэгтэйчүүдийн дадлага чадварыг хөгжүүлэх сургалтыг бий болгох асуудлыг авч үзэх
- Төрийн бус байгууллагууд эмэгтэйчүүдтэй тулж ажиллах идэвхтэн, сургагч, зээлийн ажилтнаар эмэгтэйчүүдийг авч ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх
- Эмэгтэйчүүдийг дайчлах, бүлгүүдийг үүсгэн байгуулахад Төрийн бус байгууллагуудыг гэрээгээр ажиллуулах асуудлыг авч үзэх
- Эмэгтэйчүүд шийдвэр гаргах үйл явцаас хөндий байдаг учир удирдагч бэлтгэх сургалтыг тэдний дунд зохион байгуулах асуудлыг авч үзэх

Хууль тогтоомжууд болон бодлогод өөрчлөлт оруулах замаар хадгаламж, зээлийн бүлгүүдэд эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмжих

Хууль тогтоомжууд болон бодлогод өөрчлөлт оруулах замаар хадгаламж, зээлийн бүлгүүдэд эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмжих

Индонезид хөдөө орон нутгийг хөгжүүлэх төслөөр жендэрийг асуудлыг хэрхэн амжилттай шийдвэрлэсэн тухай 9 дүгээр хайрцагт үзүүлэх болно.

9-р хайрцаг

Индонезид хөдөөгийн хөгжилд олон нийтийн эрх мэдлийг дээшлүүлэх

КЕЙС СУДАЛГАА

Индонезийн 6 мужийн 11 дүүрэгт ядуурлыг бууруулахын тулд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур нөхцөлд аж төрдөг 110 мянган өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөө орон нутгийн ядуучуудын амьжиргаанд нөлөөлөхүйц үйл ажиллагааг төлөвлөх, удирдан явуулахад тэднийг сургаж чадваржуулахад энэхүү төсөл чиглэсэн болно. Тосгодын оршин суугчдын оролцоотойгоор төлөвлөх, хот хөдөө орон нутгийг холбоход чухал шаардлагатай байгаа хөдөөгийн дэд бүтцийг хөгжүүлэх үүднээс оршин суугч олон нийтэд түшиглэсэн хадгаламж зээлийн байгууллага /ХЗБ/-уудыг үүсгэн байгуулах замаар шийдвэрлэнэ.

Индонези улсад 4.3 сая ядуу өрх байдгийн дотор 0.5 сая өрхийг эмэгтэйчүүд толгойлдог. Өөрөөр хэлбэл ядуу 10 өрх тутмын нэгийг эмэгтэйчүүд тэргүүлдэг байна.

Төсөлд хамрагдсан хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд хөдөө аж ахуй, жижиг худалдаа, хөлсний хөдөлмөр эрхлэх зэрэг олон байдлаар эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмрийг оруулдаг байна. Хэдий тийм боловч цалин хөлс бага, хөрөнгө нөөц, дадлага олгох сургалт, шаардлагатай техник технологи болон зах зээлийн боломж хомс учраас тэд олон төрлийн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна.

Төсөл эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн бөгөөд жижиг үйлдвэрлэлийг дэмжих зорилго бүхий Хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн тэн хагасыг, чадваржуулах, удирдагчдыг бэлтгэх сургалтуудад хамрагдагсдын тэн хагасыг, төслийг гардан хэрэгжүүлэх ажилтнуудын тэн хагасыг эмэгтэйчүүдээр бүрдүүлэх болно. Төсөл хэрэгжүүлэх ажилтнаар эмэгтэйчүүдийг авч ажиллуулсанаар тэдний дунд ажил эрхлэлт нэмэгдэх болно.

Тосгодын төлөвлөлтөд оролцох эмэгтэйчүүдийн бүлэг хэсгүүд байгуулагдана. Ингэснээр эмэгтэйчүүдийн аж ахуйн үйл ажиллагаа, ахуй амьдралд тулгардаг хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлох, тэдний эрэлт хэрэгцээг орон нутгийн засаг захиргааны түвшний хөгжлийн төлөвлөлтөд тусгах боломж нэмэгдэх юм. Тосгодын хэмжээний төлөвлөлтөд эмэгтэйчүүд оролцох болсноор тосгоны эдийн засгийн болон олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрдөг болсон байна.

Хадгаламж, зээлийн хоршоод эмэгтэйчүүдэд банкны албан ёсны салбаруудаас бичил үйлдвэрлэлээ хөгжүүлэх, шинэ үйлдвэрлэлд хөрөнгө оруулах боломжийг өргөжүүлнэ. Тэгсэнээр эмэгтэйчүүд үйлдвэрлэлийн баялагийг бүтээх зорилгоор газар тариалангийн болон бусад үйлдвэрлэлд хөрөнгө оруулах боломжтой болно. Төслийн хот, хөдөө орон нутгийг холбох бүрэлдэхүүн хэсгийн ачаар бараа бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийн нөхцөл боломж сайжрах болно.

Тосгодын төлөвлөлтөд болон Хадгаламж зээлийн хоршоодын удирдлагад эмэгтэйчүүд өөрсдийн хэрэгцээ шаардлагыг ярилцах боломжийг нэмэгдүүлэхийн тулд тэднийг хөгжүүлэх болон удирдагч бэлтгэх сургалтуудад тэднийг хамруулна. Хадгаламж зээлийн хоршоодын удирдах зөвлөлд эмэгтэйчүүд ажиллах болно.

Жендэрийн болон хөгжлийн асуудлаар мэргэшсэн зөвлөхүүдийг авч ажиллуулан, төрийн бус байгууллагууд төслийн хэрэгжилтэд эмэгтэйчүүд хамтран оролцсоноор бичил зээлийн болон хадгаламж, зээлийн байгууллагуудын ажиллагаанд эмэгтэйчүүд тэгш эрхтэй оролцох боломж бүрдэх төдийгүй жендэрийн ялгавартай мониторингийн тогтолцоо бий болно.

Аж үйлдвэрлэлийн зориулалттай газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- ➔ Төсөлд хамрагдах нутгийн хүн амын талаарх /Хүн ам, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд, жендэрийн хөдөлмөрийн хуваарь, үйлдвэрлэлийн гол үйл ажиллагаанд зориулагддаг цаг хугацаа/ мэдээллийг жендэрийн ялгавартай ангилсан уу?
- ➔ Тариачин өрхүүдийн хэдэн хувийг эмэгтэйчүүд толгойлдог вэ? Тэдгээр өрхийн нөхрүүдийнх хэдэн хувь нь өөр газарт тусдаа амьдардаг вэ?
- ➔ Тариалангийн талбайд уламжлалын дагуу аль ажлыг эмэгтэйчүүд, алийг нь эрэгтэйчүүд хийдэг вэ?
- ➔ Боловсруулах болон туслах чанарын ямар ажил, үйлчилгээг эмэгтэйчүүд, алийг нь эрэгтэйчүүд хийж гүйцэтгэдэг вэ?
- ➔ Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хийдэг ажил гэж ангилахад ямар хүчин зүйлүүд нөлөөлдөг вэ?
- ➔ Шинээр нэвтрүүлсэн техник технологи эмэгтэйчүүдийн хийдэг ажилд хэрхэн нөлөөлдөг вэ?
- ➔ Төсөлд санал болгож буй өөрчлөлтүүд тухайн орон нутгийн жендэрийн хөдөлмөрийн хуваарьт хэрхэн нөлөөлөх вэ?
- ➔ Өрхийн тариаланд газар өмчлөлийн ямар хэлбэрүүд байдаг вэ? Газар ашиглах эрхийг эмэгтэйчүүд хэдий хэмжээгээр бие даан дангаараа болон хамтран эзэмшдэг вэ?
- ➔ Ямар талбайд, ямар ургамал тариалахыг хэн, хэрхэн шийддэг вэ?
- ➔ Ургацаа борлуулсаны орлогыг хэн захиран зарцуулдаг вэ? Өрхийн дотор уг орлого хэрхэн хуваарилагддаг вэ? Орлогыг хэн, хэрхэн хуваарилан, зарцуулдаг вэ?

ЗӨВЛӨМЖ

Төслийг

хэрэгжүүлэх

ажилтнаар

орон нутгийн

эмэгтэйчүүдийг

ажилуулахад

анхаарах

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс эрэгтэйчүүдийн олсон орлого хэрхэн зарцуулагддаг вэ? Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс эмэгтэйчүүдийн олсон орлого хэрхэн зарцуулагддаг вэ?
- Аж үйлдвэрийн зориулалттай газар тариалан нэмэгдэх нь эмэгтэйчүүдийн өрхийн амьжиргааны аж ахуйн газрын хэмжээг багасгах уу? Ямар үр дагавар учруулах вэ?
- Аж үйлдвэрийн зориулалттай ургамал тарьж борлуулахад эмэгтэйчүүдэд ямар саад бэрхшээл тулгардаг вэ?
- Өрх толгойлсон эмэгтэйчүүд хуулийн дагуу газар өмчлөх, тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэлийн орлогоос хувь хүртэх эрхтэй юу? Эдгээрт ямар ямар эрх багтдаг вэ?
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн газар тариалангийн үйл ажиллагаа нь дараахи хүчин зүйлээр бусад аж ахуйгаас хэрхэн ялгардаг вэ?
 - Арилжааны зориулалттай тариалантад оролцох
 - Хэрэгсэлүүдийг ашиглах /химийн бордоо, сайжруулсан үр/
 - Тодорхой хугацаанд ажилчин авч ажиллуулах боломж
 - Хөдөө аж ахуйн техник технолги хэрэглэх

Гол стратегиуд

- Эмэгтэйчүүдэд болон эрэгтэйчүүдэд төслийн хүрээнд ажил, орлого олох бололцоо олгох
- Төслийн холбогдолтой ажил гүйцэтгэсэн эмэгтэй, эрэгтэйчүүд ижил урамшил, хөлс авах нөхцлийг бүрдүүлэх
- Хөдөө аж ахуйд ажилчин авч ажиллуулахдаа тухайн нутгийнхныг хамруулдаг байх, уналга тээврийн хувьд хангах, тэдгээрийг эмэгтэйчүүд хэрэглэхэд боломжтой төдийгүй хүртээмжтэй байлгах
- Эхчүүдийн, эрүүл мэндийн, хүүхэд асрах үйлчилгээ, эмэгтэйчүүдийг бичиг үсэгт сургах сургалт, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах ажлыг зохион байгуулах

- Эмэгтэйчүүдийн цаг зав, хүч хөдөлмөрийг хэмнэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх шинэ техник, технологи нэвтрүүлэх асуудалд анхаарах
- Ахуйн буюу амьжиргааны тариалангийн газрыг эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах
- Хүнсний ногооны тариалахад зориулсан зарим нэгэн тоног төхөөрөмжийг олгох
- Тариалангийн үйлдвэрлэлд эмэгтэйчүүдэд тэгш эрхтэй оролцох

Балбад үр тарианы нэр төрлийг олшруулах төсөлд жендэрийн асуудлыг хэрхэн түлхүү анхаарсан тухай 10 дугаар хайрцагнаас үзэж болно.

10 дугаар хайрцаг

Балбад үр тарианы төрөл зүйлийг олшруулсан төсөл

КЕЙС СУДАЛГАА

Хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад эмэгтэйчүүдийн оруулж байгаа чухал хувь нэмрийг Балбад ихэд доогуур үнэлдэг бөгөөд хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр хэрэгждэг хөтөлбөрүүдийн ашиг тусыг хүртэх боломж тэдний хувьд үлэмж хязгаарлагдмал явж ирсэн аж. Энэ байдлыг засч залруулахын тулд тариачдын бүлэг байгуулж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон борлуулалтад зохистой хандлагыг нэвтрүүлэхэд энэхүү төсөл чиглэгдсэн байна.

Эмэгтэй тариачдыг маркетингийн үйл ажиллагаа, өргөтгөсөн үйлдвэрлэл явуулах үйлчилгээнд түлхүү үүрэгтэй оролцуулахын тулд тэднийг нэгтгэсэн бүлгийг байгуулах шаардлагатай болсон аж. Эрэгтэй, эмэгтэй тариачдыг хамарсан бүлэгт удирдах үүрэг гүйцэтгүүлэхийн тулд эмэгтэйчүүдийг сургах болсон байна. Эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс үзүүлдэг үйлчилгээнүүдийг хэлэлцэн тохиролцох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг төвүүдийг орон нутгийн зах зээлтэй холбоход бүлгийн хувьд оролцох боломжийг эмэгтэй тариачдын бүлэг тэдэнд олгох аж.

Жендэрийн болон бие биеийнхээ эрэлт хэрэгцээг илүү сайтар ойлгох, үр тарианы нэр төрлийг олшруулах, үйлдвэрлэл явуулах, борлуулах талаар эмэгтэйчүүд болон бусад тариачдын дунд сүлжээ үүсгэх, тэдний мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх сургалтуудад эмэгтэй, эрэгтэй тариачдыг хамруулах болсон байна. Хөдөө аж ахуйн өргөтгөсөн үйлдвэрлэл явуулах, эмэгтэй, эрэгтэй тариачдын хэрэгцээ шаардлагыг хангах арга ажиллагааны тухай гарын авлагуудыг боловсруулж бэлтгэх зорилгоор хөдөө аж ахуйн ажилтнуудыг сургасан аж. Төслийн үйл ажиллагаанд эмэгтэй, эрэгтэй тариачдын жигд оролцоог хангахад чиглэсэн оршин суугчдын талаархи жендэрийн ялгавартай мониторинг явуулахаар мэдээллийн санг байгуулсан байна.

Мал аж ахуй дахь жендэрийн асуудлууд

Гол асуудлууд

- Төсөлд хамрагдсан нутагт мал сүргийг өсгөн үржүүлэх, арчилж хамгаалахад эмэгтэй, эрэгтэйчүүд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- Мал сүргийг арчилж хамгаалах ямар ямар ажлыг уламжлалын дагуу эмэгтэйчүүд голлон хариуцдаг, дор дурдсан чухам ямар ажилд эмэгтэйчүүд өдөр тутам эсвэл байнга оролцдог вэ? Тухайлбал,
 - Тэжээл бэлтгэх, цуглуулах болон тэжээх
 - Услах
 - Цэвэрлэх
 - Малаа хариулах
 - Сүү саах, малын ашиг шимийг нь цуглуулах бусад ажиллагаа
 - Өвчин эмгэгтэй малыг асарч тордох
- Мал сүргийг асарч хамгаалахад эмэгтэй, эрэгтэйчүүдийн зарцуулдаг хүч хөдөлмөрт төсөл ямар нөлөө үзүүлэх вэ? Эмэгтэй, эрэгтэйчүүд илүү эсвэл бага ажилладаг болох уу?
- Үйлдвэрлэлийн шинэ төрлийн арга ажиллагаа төсөлд хамрагдах тохиолдолд тэдгээрийг эмэгтэйчүүд хийх үү? эсвэл эрэгтэйчүүд хийх үү? Ажил шилжин ирэх үү? Эдгээр өөрчлөлтүүд эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлөх вэ ?
- Мал аж ахуйн хөгжилд төслийн оруулах хувь нэмэр нь нийт аж ахуйн тогтолцоонд эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг үүрэгт нөлөөлөх үү? Нөлөөлөх бол ямар хэмжээгээр?
- Арилжааны мал аж ахуйн техник технологийг эрэгтэйчүүдэд олговол эмэгтэйчүүдийн уламжлалт ажлын ачаалал, хариуцлагад хэрхэн нөлөөлөх вэ?
- Төсөл эмэгтэйчүүдийн ажлын ачаалалыг нэмэгдүүлэх үү? Тийм бол тэдэнд ямар ашиг ногдох вэ?

- Мал аж ахуйн шинэ арга техник, шинэ маягийн мал аж ахуй газар ашиглалтад ямар нөлөө үзүүлэх вэ? Тэдгээр нь эмэгтэйчүүд газрын ашиглах хүртээмжийг сайжрах уу?
- Эмэгтэйчүүд төсөлд хамрагдан оролцох боломж /газар, зээл, мөнгө хөрөнгө/ бий юу?, Эрчимжсэн мал аж ахуй, сайжруулсан тэжээл, бусад хэрэгсэлийн ашиг тус тэдэнд ногдох уу?
- Боловсруулах, борлуулах хоршооллууд, олон нийтийн төслүүдэд эмэгтэйчүүд оролцдог уу?
- Эмэгтэйчүүд малаа өөрсдөө өмчилдөг үү? Мах, өндөг, сүү гэх мэтийг зарж борлуулсаны орлогыг тэд захиран зарцуулдаг уу? Хувь хүртдэг үү?

Гол стратегиуд

- Сайжруулсан мал сүрэг болон төслийн бусад авч ашиг шимийг нь хүртэгчдийн тоонд эмэгтэйчүүдийг оруулах
- Цөөн тооны малыг асарч арчлах ажил ихэвчлэн эмэгтэйчүүдэд ногддог учир тэдэнд дэмжлэг үзүүлэх төсөлд анхаарал хандуулах
- Мал аж ахуйд эмэгтэйчүүдийн оролцоо, хяналтыг багасгалгүйгээр зарцуулдаг хугацаа, хүч чармайлтыг нь илүү үр өгөөжтэй ашиглах арга замыг судалж үзэх
- Эмэгтэй, эрэгтэйчүүд тус тусдаа орлоготой, санхүүгийн үүрэг хариуцлагыг өөр өөртөө хүлээдэг тохиолдолд эмэгтэйчүүдийн ердийн орлогын эх үүсвэрийг хамгаалах, орлогын шинэ эх үүсвэрийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- Мал сүргээ асарч хамгаалахад нь эмэгтэйчүүдэд тусалж тэднийг мал эмнэлгийн сургалтад хамруулах
- Нүүх шилжин суурьших нь эмэгтэйчүүдэд хүндрэлтэйг харгалзан аливаа сургалтыг хот суурин газруудад бус харин хөдөө тосгодод зохион байгуулах

ЗӨВЛӨМЖ

Мал сүргээ

хамгаалахад

эмэгтэйчүүдэд

тусалж

тэднийг мал

эмнэлгийн

сургалтад

хамруулах

➔ Мал аж ахуй үйлдвэрлэл болон борлуулалтанд эмэгтэйчүүдийг оролцуулах, сургахын тулд төрийн бус байгууллагуудтай ажиллах

➔ Техникийн аливаа дэмжлэг, үйлчилгээ эмэгтэйчүүдэд хүрч байх нөхцлийг хангах

Мал аж ахуйд жендэрийн асуудлыг анхаарсан төслийг 11 дүгээр хайрцагт үзэж болно.

11 дүгээр хайрцаг

Бангладешт мал аж ахуйн төсөлд оролцооны аргыг дэмжсэн төсөл**КЕЙС
СУДАЛГАА**

Мал аж ахуйн үйлдвэрлэлд эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг зонхилох үүрэг, тэдэнд тулгардаг бэрхшээл, зээл зах зээлийн хомсдолд анхаарал хандуулах, жендэрийн тэгш бус байдлыг төсөлд бэлтгэх техникийн туслалцааны шатанд тодруулсан байна. Цөөвтөр мал сүргийг өсгөж үржүүлэх арчлан хамгаалах ажлыг дийлэнхдээ эрэгтэйчүүдэд бус харин эмэгтэйчүүдэд ногддог боловч төрийн байгууллагуудын хэрэгжүүлдэг өргөтгөлийн болон сургалтын хөтөлбөрүүд үүнийг ямагт орхигдуулдагийг төсөл илрүүлсэн байна.

Дурдсан хөтөлбөрүүд ихэвчлэн хот суурин газруудад явагддаг нь зорчиж явахад бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн оролцоонд хүндрэл учруулдаг. Мал аж ахуйгаа өргөжүүлэхэд шаардлагатай зээлийн хүртээмж эмэгтэйчүүдэд үгүйлэгддэг. Төрийн бус байгууллагууд өргөтгөлийн болон сургалтын хөтөлбөрүүдийг хөдөө орон нутгуудад зохион явуулдаг учир тэдгээрт эмэгтэйчүүдийн оролцоо өндөр байдаг аж. Төрийн бус байгууллагууд тэрчлэн эмэгтэйчүүдэд мал, тоног төхөөрөмж, худалдан авах бичил санхүүжилт олгох, төрийн мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаггүй тосгодод техникийн үйлчилгээ үзүүлэх арга замууд бийг илтгэн харуулж байгаа юм.

Аж ахуйн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцогчийн хувьд эмэгтэйчүүдэд хандах зэргээр төсөл өөрийн төлөвлөлтөд жендэрийн асуудлыг анхаарч байна. Төслийн үр шимийг хүртэгчдийн далаас наян хувь нь эмэгтэйчүүд байх бөгөөд төрийн бус байгууллагуудаар дамжуулан 340 мянган өрхөд ялангуяа өрх толгойлсон, эдэлбэр газар үгүй эмэгтэйчүүдэд бичил зээл олгож тэднийг шувуу үржүүлэх, үхэрт тарга тэвээрэлг авахуулах, ямаа өсгөх ажил эрхлүүлэх аж. Төрийн бус байгууллагууд эмэгтэйчүүдийн дунд тосгодод суурилсан өргөтгөлийн болон сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бөгөөд 10.8 мянган эмэгтэй сургалтад хамрагдаж, тосгодод суурилсан тэжээл, тарилга, маркетингийн үйлчилгээг бий болгох юм.

Хавсралт

ЖЕНДЭРИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Зөвлөх нь жендэрийн эсвэл эмэгтэйчүүдийн судалгааны асуудлаар дипломын дараах сургалтад хамрагдаж, зэрэг хамгаалсан ялангуяа Ази, Номхон далайн бүс нутгийн хөдөө аж ахуй, орон нутгийн хөгжил дэх жендэрийн асуудлаар төсөл төлөвлөх нэлээд туршлагажсан байх шаардлагатай. Зөвлөхийн хариуцах ажил үүрэгт доорх зүйлсийг хамруулах боловч түүгээр хязгаарлагдана гэсэн үг биш юм. Тухайлбал,

➔ Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд тухайн салбарт нөлөөлж буй жендэрийн болон хөгжлийн томоохон бодлогуудын жагсаалтыг гаргах

➔ Хийгдсэн судалгаа мэдээлэл дээр үндэслэн төсөл бэлтгэх, боловсруулахад зайлшгүй шаардлагатай жендэрийн болон хөгжлийн асуудлуудыг тодорхойлох

➔ Жендэрийн дүн шинжилгээ хийх

➔ Нөхөн үржихүйн хуваарь болон эмэгтэй, эрэгтэйчүүдэд олдох хөрөнгө мөнгө, үйлчилгээ, зах зээлийн хүртээмж, төслийн үйл ажиллагааны үзүүлэх үр нөлөө, тэдгээрийн үр дагаварын талаар мэдээлэл олж авах зорилгоор өрхийн судалгаа хийх.

Энэ ажлыг гүйцэтгэхдээ дараахи чиглэлээр дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- Жендэрийн ялгаанд тулгуурлан ажил хуваариладаг хэлбэрүүд, тэдгээр нь харьцангуй хэр хэвшмэл болох,
- Үйлдвэрлэлийн хэрэгсэлийн хүртээмж, тэдгээр тавих хяналт
- Хөдөлмөрийн ашиг шимийг хүртэх, тэрхүү ашиг шим /цалин хөлс, орлого, цэвэр ашиг, хадгаламж/-ийг захиран зарцуулах, хэрэглэх боломж эмэгтэй, эрэгтэйчүүдэд ямар байдаг
- Хөдөлмөрийн бүтээмж, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өргөтгөлийн болон сургалт эмэгтэй, эрэгтэйчүүд хэрхэн хүртэж байгаа
- Шийдвэр гаргахад жендэрийн ялгаатай давуутай болон хүндрэлтэй тал

➔ Жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн практик хэрэгцээг хангахад чиглэсэн механизм, стратегийг боловсруулж зөвлөмж болгох, онцлог талыг төлөвлөх, дараахи эмэгтэйчүүдийн стратегийн байр суурийг бэхжүүлэх ажлуудыг санал болгох

- Төслийн хүрээнд шаардагдах үйлдвэрлэлийн хэрэгсэлийн эмэг-

тэйчүүдэд олдох хүртээмжийг сайжруулах, төслөөс эмэгтэйчүүдийн байр суурьт учирч болох сөрөг үр дагавараас зайлсхийх арга зам,

- Сургалтад эмэгтэйчүүдийн оролцоо, тэдэнд мэдээлэл, өргөтгөл үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга зам,
- Гэр ахуй хүнд хүчир ажлыг багасгах, чөлөөт цагийг нэмэгдүүлэх, орлогоо нэмэгдүүлэх цагийг нь уртасгах, амьдралыг бүхэлд нь сайжруулахад чиглэсэн суурь үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээ
- Эмэгтэйчүүдэд үйлчилгээ, хэрэгсэл, зах зээлийг хүртээмжтэй болгох зорилгоор үйлдвэрлэлд оролцох оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ
- Бичил зээл, үйлчилгээтэй холбоотойгоор бүлэг байгуулах, сургалт явуулах зэргээр эмэгтэйчүүдийн хадгаламж, зээлийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих тусламж

➔ Дээр дурдсан жендэрийн дүн шинжилгээнд үндэслэн жендэрийн стратегийн эрэлт хэрэгцээний түвшинд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ:

- Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүний үр ашгаас хүртэх, менежмент, мониторинг, үнэлгээнд оролцох боломжийн талаарх шийдвэрийг гаргахад эмэгтэйчүүдийн бүрэн оролцоог хөхүүлэн дэмжих аргыг тодорхойлох
- Шийдвэр гаргах, хөгжлийн боломжоос хүртэх талаар айл өрх, олон нийтийн доторх эмэгтэйчүүдийн эрх мэдлийг бэхжүүлэх
- Жендэрийн дүн шинжилгээний үр дүнг төслийн төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээнд тусгах
- АХБ-ны ерөнхийлөгчийн илтгэл, зөвлөмжид хавсаргах. Жендэрийн болон хөгжлийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тухай тодорхой жендэрийн стратегийг бэлтгэх

Эх сурвалжийн түүвэр

Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг,
1997 он, *Жендэр болон Хөгжлийн удирдамж*.

Моника Фонг, Анжана Бушан,
1996, *ХАА- дахь Жендэрийн гарын авлага,
Жендэрийн цуврал гарын авлага, Дугаар 1,*

Вашингтон, Дэлхийн Банк
Каролин Мозэр, 1993, *Жендэрийн Төлөвлөлт
болон Хөгжил, Онол, Дадлага, Сургалт,
Лондон*

Вики Вайлд, Аря Вайно Матилла, 1995 ,
Жендэрийн дүн шинжилгээ, болон Ой мод.
Олон улсын сургалт, Хүнс, ХАА-н
байгууллага.
